

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2008 оны 01 дүгээр
сарын 31-ний өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Журам батлах тухай

“Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 6.1.2 дахь заалт, “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль”-ийн 4.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Банк бус санхүүгийн байгууллагад мөрдөх “Банк бус санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх үлгэрчилсэн заавар”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журам, зааврыг 2008 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Банк бус санхүүгийн байгууллагын төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх захирал нарт үүрэг болгосугай.

3. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2004 оны 167 дугаар тушаалаар батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн үлгэрчилсэн багц журам”-ыг хүчингүй болсонд тооцуулах хүсэлтийг Монголбанкинд тавьж, шийдвэрлүүлэхийг СЗХ-ны Ажлын алба /О.Ганбат/-нд үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан зааврыг нийтэд сурталчлах, биелэлтэд нь хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөлгөө өгч ажиллахыг Банк бус санхүүгийн байгууллагын газар /Х.Бум-эрдэнэ/ -т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны
2008 оны 05 дугаар тогтоолын хавсралт

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН НЯГТЛАН
БОДОХ БҮРТГЭЛИЙГ ХӨТЛӨХ
ҮЛГЭРЧИЛСЭН ЗААВАР

Санхүүгийн зохицуулах хороо

2008 он

АГУУЛГА

А-1. Нийтлэг үндэслэл

А-2. Дансны жагсаалт

Б–ХӨРӨНГӨ

Б-1. Мөнгөн хөрөнгө

Б-1.1. Бэлэн мөнгө

1-1.1. Бэлэн мөнгөний бүртгэл

1-1.2. Кассын илүүдэл, дутагдал

1-1.3. Бэлэн мөнгөний зузаатгал

1-1.4. Тоолж шалгаагүй бэлэн мөнгө

Б-1.2. Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгө

Б-2. Богино хугацаат хөрөнгө оруулалт

Б-2.1. Үнэт цаас худалдан авах, худалдах

Б-2.2. Үнэт цаасны хорогдуулаагүй нэмэгдүүлэлт ба хямдруулалт

Б-3. Зээл

Б-3.1. Зээл олгох, төлүүлэх

Б-3.2. Зээлийн хүүгийн бүртгэл

Б-3.3. Зээлийн ангилал, ЗЭС байгуулах, зарцуулах

Б-3.4. Зээлийн барьцаа, батлан даалтын хөрөнгө

Б-4. Санхүүгийн түрээс

Б-4.1. Санхүүгийн түрээсийн бүртгэл

Б-5. Факторингийн үйлчилгээ

Б-5.1. Факторингийн авлагын бүртгэл

Б-5.2. Факторингийн тооцоогоор үүссэн авлагын ангиллыг өөрчлөх

Б-5.3. Факторингийн авлагын эрсдэлийн сан /ФАЭС/-ийн бүртгэл

Б-6. Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө

Б-6.1. Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн бүртгэл

Б-7. Бусад хөрөнгө

Б-7.1. Авлагын бүртгэл

Б-7.2. Салбар хоорондын тооцооны бүртгэл

Б-7.3. Урьдчилгаа тооцооны бүртгэл

Б-7.4. Материал, үнэ бүхий зүйлсийн тооцооны бүртгэл

Б-8. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл

Б-8.1. Форвард, фьючерс

Б-8.2. Своп

Б-8.3. Опшин

Б-8.4. Спот

Б-8А. Гадаад валютын арилжаа

Б-8А1. Бэлэн гадаад валютын арилжаа

Б-8А2. Гадаад валютын ханшийн тэгшитгэл

Б-9. Үндсэн ба биет бус хөрөнгө

Б-9.1. Үндсэн хөрөнгийн бүртгэл

9.1.1 Үндсэн хөрөнгийг бэлтгэх, худалдан авах

9.1.2 Үндсэн хөрөнгийг бусдад худалдах

9.1.3 Үндсэн хөрөнгийг ашиглалтаас хасах

9.1.4 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ

Б-10. Биет бус хөрөнгө

Б-10.1. Биет бус хөрөнгийн бүртгэл

В-ӨР ТӨЛБӨР

В-1. Итгэлцлийн үйлчилгээ

В-1.1. Итгэлцлийн бүртгэл

В-2. Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл

В-2.1. Зээлийн бүртгэл

В-3. Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ

В-3.1. Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын бүртгэл

В-4. Банк бус санхүүгийн байгууллагаас гаргасан өрийн бичиг

В-4.1. Өрийн бичгийн бүртгэл

В-5. Төслийн зээлийн санхүүжилт

В-5.1. Төслийн зээлийн санхүүжилтийн бүртгэл

В-6. Бусад өр төлбөр

В-6.1. Бусад өр төлбөрийн бүртгэл

Г-ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

Г-1. Хувьцаат капиталын бүртгэл

Г-2. Хандивын капиталын бүртгэл

Г-3. Хуримтлагдсан ашгийн бүртгэл

Г-4. Ашгийн хуваарилалтын бүртгэл

Г-5. Хоёрдогч өглөгийн бүртгэл

Д-ОРЛОГО БА ЗАРДАЛ

Д-1. Орлого ба олз

Д-1.1 Орлого ба олзын бүртгэл

Д-2. Зардал ба гарз

Д-2.1. Зардал ба гарзын бүртгэл

Е-САНХҮҮГИЙН ЖИЛИЙН ХААЛТЫН ГҮЙЛГЭЭ

Е-1. Санхүүгийн жилийн хаалтын гүйлгээний бүртгэл

Ё-БУСАД

Ё-1. Тэнцлийн гадуурх дансд

Ё-2. Төлбөрийн баталгаа

Ё-2.1 Төлбөрийн баталгааны бүртгэл

Ё-3. Хяналт, хариуцлага

А-1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Санхүүгийн зохицуулах хорооноос (цаашид Хороо гэх) үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан Банк бус санхүүгийн байгууллага нь (цаашид ББСБ гэх) энэхүү дансны үлгэрчилсэн зааврыг үндэслэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэнэ.

1.2 ББСБ-ын нягтлан бодох бүртгэлийн заавар нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид СТОУС гэх), Монгол улсад мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн үндсэн зарчмууд дээр үндэслэсэн бөгөөд энэ журамд нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг зөвхөн Хороо хариуцна.

1.3 Энэхүү үлгэрчилсэн зааварт тулгуурлан ББСБ-ууд дотооддоо СТОУС болон Монгол Улсад мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн үндсэн зарчмуудад бүрэн нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлого, журам, дансны дэлгэрэнгүй жагсаалтыг боловсруулж мөрдөх шаардлагатай.

1.4 ББСБ нь нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлж, ажил гүйлгээг давхар бичилтийн хэлбэрээр бүртгэнэ.

1.5 Нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлтийн нэгж нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөг, мөнгөөр илэрхийлэгдсэн байна.

1.6 Байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулж, нягтлан бодох бүртгэл хөтөлөлт, санхүүгийн тайлан бусад мэдээ баримтыг үнэн зөв гаргаж энэ талаар холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

А-2. ДАНСНЫ НЭГДСЭН ЖАГСААЛТ

Дансны нэгдсэн жагсаалт нь ББСБ –ын үйл ажиллагааны онцлогийг бүрэн тусгасан, нягтлан бодох бүртгэлээр дамжуулан хүлээн авах мэдээллийн хэрэгцээг бүрэн хангахуйц бүртгэлийн үйл ажиллагааг СТОУС-ын жишгийн дагуу ангилсан дансны нэр болон дугаараас бүрдсэн системчилсэн жагсаалт байна.

Дансны нэгдсэн жагсаалт нь тэнцлийн болон тэнцлийн гадуурх данснаас бүрдэнэ. Тэнцлийн дансанд актив, пассив, өөрийн хөрөнгө, орлого, зарлагын данс багтана.

Дансны дугаар нь 7 хүртэлх оронтой тоо байна. Эхний 4 орон нь дансны төрөл, бүлэг, зүйлийг тодорхойлно. Сүүлийн 3 оронг ББСБ өөрөө тогтоох бөгөөд тэдгээр нь нэрийн дансны дугаарыг илэрхийлнэ.

ББСБ өөрийн дотоод үйл ажиллагаанд 8-16 хүртэлх оронтой дансны дугаарыг хэрэглэж болох ба өөрийн дотоод үйл ажиллагаанд ашиглаж буй дансны жагсаалтыг Хорооноос баталсан дансны кодонд нийцүүлэн тайлагнана.

Дансны дугаарын эхний орон нь дансны төрлийг тодорхойлно

Данс нь дараах үндсэн төрөлд хуваагдана. Үүнд:

- Хөрөнгө
- Өр төлбөр
- Өөрийн хөрөнгө
- Орлого
- Зарлага
- Тэнцлийн гадуурх

“Хөрөнгө” гэдэг нь өнгөрсөн хугацааны үйл ажиллагааны үр дүнд үүсч бий болсон, тухайн байгууллагын эзэмшилд байгаа, ирээдүйд эдийн засгийн үр ашиг, үйлчилгээний чадавхиа өгөх нөөц юм.

“Өр төлбөр” гэдэг нь бусдын өмнө хүлээсэн эдийн засгийн үүрэг, хариуцлага юм.

“Эзэмшигчдийн өмч” гэдэг нь ББСБ-ын нийт хөрөнгөөс өр төлбөрийг хасаад үлдэх дүн буюу дүрмийн сан, бусад сангууд, ашиг, алдагдлаас бүрдэх хөрөнгийг хэлнэ.

“Балансын /тэнцлийн/ гадуурх дансны бүртгэл” гэдэг нь ирээдүйд хүлээж болзошгүй үүрэг, үнэ бүхий зүйл зэргийг зориулалтаар хэрэглэж буй эсэхийг тэнцлийн гадуур давхар бүртгэсэн данс бүртгэлийг хэлнэ.

Б-ХӨРӨНГӨ

1. Тодорхойлолт

Өнгөрсөн хугацааны үйл ажиллагааны үр дүнд үүсч бий болсон, тухайн байгууллагын эзэмшилд байгаа, ирээдүйд эдийн засгийн үр ашиг, үйлчилгээний чадавхиа өгөх нөөцийг хөрөнгө гэнэ. Нягтлан бодох бүртгэлд хөрөнгийг эргэлтийн ба эргэлтийн бус гэж ангилна.

Хөрөнгө нь гурван үндсэн чанарыг агуулна. Үүнд:

1. Хөрөнгө нь дангаараа буюу бусад хөрөнгөтэй хослон, шууд ба шууд бус замаар цэвэр мөнгөн гүйлгээ буюу үйлчилгээг нэмэгдүүлэх чадавхи бүхий ирээдүйн үр ашгийг агуулж байна;

2. ББСБ хөрөнгөөс олох үр ашигт хяналт тавьж чадахуйц байна;

3. ББСБ олсон үр ашгаа хянах буюу захирах эрх мэдлийг нэмэгдүүлэх ажил гүйлгээ хийгдэнэ;

2. Хамрагдах зүйлс

- Мөнгөн хөрөнгө
- Богино хугацаат хөрөнгө оруулалт
- Зээл
- Өмчлөх бусад хөрөнгө
- Бусад хөрөнгө
- Үндсэн хөрөнгө
- Биет бус хөрөнгө

Эргэлтийн хөрөнгөд мөнгөн хөрөнгө, богино хугацаат хөрөнгө оруулалт, өмчлөх бусад хөрөнгө, дансны авлага, урьдчилж төлсөн төлбөр, хангамжийн зүйлс орно.

3. Хөрөнгийн үнэлгээ

3.1 Хөрөнгийг хянаснаар эдийн засгийн үр ашиг буюу үйлчилгээний гүйлгээ чадавхийн ойролцоо дүнг хамгийн бодитоор тооцож чадах үнэлгээний аргыг хөрөнгийн үнэлгээнд сонгож хэрэглэх хандлагыг баримтална. -

3.2 Хөрөнгийн бүртгэлийн цэвэр дүн нь нэмэлт, сайжруулалт болон шилжүүлэлтийн дүнгээр тохируулагдсан анхны өртөг эсвэл үнэлгээнээс элэгдэл эсвэл тухайн үед данснаас хассан дүнг хассан зөрүү юм.

3.3 Хөрөнгийн цэвэр үнэ цэнэ гэж хөрөнгийг ашиглалтын хугацаа нь дуусах үед зарж борлуулах боломжтой үнээс ашиглалтаас хасах үед хүлээгдэж буй зардлыг хассан дүн юм.

3.4 Зээл, авлага болон гэрээнд заасан хугацаа нь дуусгавар болтол эзэмших хөрөнгө оруулалтыг өртгөөр нь бүртгэнэ. Эдгээр хөрөнгийн эрсдэлийн санг зардлаар байгуулах бөгөөд эрсдэлийн сангийн хэмжээг бодит хүүгийн аргаар тооцно

ББСБ нь зээл, хүлээж болзошгүй үүрэг, үнэт цаас болон бусад активын хугацааны ба чанарын үзүүлэлтийг тооцож, эрсдэлийн санг Монголбанкны Ерөнхийлөгч, СЭЗ-ийн сайдын хамтарсан 2004 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 459/207 тоот тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”, 2006 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 147/94 тоот тушаалаар батлагдсан тус журамд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу байгуулна.

Б-1. МӨНГӨН ХӨРӨНГӨ

1. Хамрагдах зүйлс

Байгууллагын касс болон банкин дахь харилцах, хадгаламжийн дансанд байгаа төгрөг, гадаад валютаас бүрдэнэ.

2. Үнэлгээ

Мөнгөн хөрөнгийг нэрлэсэн үнээр бүртгэнэ. Гадаад валютыг тухайн үеийн Монголбанкны ханшаар тооцон төгрөгт хөрвүүлэн төгрөг, валютаар давхар бүртгэнэ.

3. Санхүүгийн тайланд тусгах нь

Мөнгөн хөрөнгө нь балансын “Эргэлтийн хөрөнгө” гэсэн бүлгийн эхний зүйл ангид бүртгэнэ.

Б-1.1. Бэлэн мөнгө

1. Тодорхойлолт

Үндэсний болон гадаад улсын цаасан мөнгөн тэмдэгт, зоос, бутархай мөнгийг Бэлэн мөнгө гэнэ.

Бэлэн мөнгөөр өдөр тутмын орлого, зарлагын гүйлгээ хийх касс дахь бэлэн мөнгийг Касс дахь мөнгөн хөрөнгө гэнэ.

ББСБ-ын салбар хооронд бэлэн мөнгийг шилжүүлэх хугацаанд түр бүртгэсэн мөнгийг Замд яваа бэлэн мөнгө гэнэ.

Тоолох тасагт байгаа тоолж шалгаагүй түр бүртгэгдсэн мөнгийг Тоолж шалгаагүй бэлэн мөнгө гэнэ.

2. Үнэлгээ

Мөнгөн хөрөнгийг нэрлэсэн үнээр нь бүртгэнэ. Гадаад валютыг Монголбанкнаас зарласан тухайн үеийн ханшаар тооцон төгрөгт хөрвүүлэн төгрөг, валютаар давхар бүртгэнэ.

3. Санхүүгийн тайланд тусгах нь

Балансын Хөрөнгө талд “Эргэлтийн хөрөнгө” гэсэн бүлгийн Мөнгөн хөрөнгийн 1 дэх зүйл ангиар тусгана

4. Хяналт ба бүртгэл

Кассын харуул хамгаалалт, аюулгүй байдлыг хангаж, кассын үлдэгдэлд гэнэтийн болон тогтмол шалгалт хийнэ. Баримт материал, түүнтэй холбогдох файлын хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдал, гүйлгээний баримтын бүрдлийг хангана.

Кассын дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөж, кассын гүйлгээний баримтыг үндсэн баримттай нь тулган өдөр тутам шалгана.

Бэлэн мөнгөний үлдэгдлийг тэнцлийн үлдэгдэлтэй өдрийн гүйлгээний эцэст нийлж тохируулна.

Б-1.1. БЭЛЭН МӨНГӨНИЙ БҮРТГЭЛ

1-1.1 Бэлэн мөнгөний орлого, зарлагын гүйлгээ

Бэлэн мөнгөний орлогын гүйлгээ хийхэд:

Дебет: Касс дахь бэлэн мөнгө

Кредит: Холбогдох данс /жишээ нь: Зээлийн данс/

Бэлэн мөнгөөр зарлагын гүйлгээ хийхэд:

Дебет: Холбогдох данс /жишээ нь: Зээлийн данс/

Кредит: Касс дахь бэлэн мөнгө

Гуйвуулгаар ирсэн мөнгийг бүртгэж авахад:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс

Кредит: Мөнгөн гуйвуулгын өглөг

Гуйвуулгын мөнгийг олгоход:

Дебет: Мөнгөн гуйвуулгын өглөг

Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

1-1.2 Кассын илүүдэл, дутагдал

Кассаас мөнгө илүүдвэл илүү гарсан дүнгээр:

Дебет: Касс дахь бэлэн мөнгө

Кредит: Илүүдэл

Мөнгө илүүдсэн шалтгаан, холбогдох эзэн нь тогтоогдохгүй бол ББСБ-ын орлого болгож:

Дебет: Илүүдэл

Кредит: Бусад орлого

Холбогдох эзэн холбогдогч нь тогтоогдож илүүдэл мөнгийг буцааж олговол:

Дебет : Илүүдэл

Кредит: Холбогдох данс /жишээ нь: Касс дахь бэлэн мөнгө/

Кассаас мөнгө дутвал дутагдсан дүнгээр:

Дебет: Дутагдал

Кредит: Касс дахь бэлэн мөнгө

Дутсан шалтгаан нь тогтоогдож холбогдох эзнээр төлүүлбэл:

Дебет : Холбогдох данс жишээ нь: /Касс дахь бэлэн мөнгө/

Кредит: Дутагдал

Хэрэв мөнгө дутаасан эзэн холбогдогч нь тогтоогдоогүй, нас барсан, төлбөрийн чадваргүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон тохиолдолд дутагдлыг ББСБ-ын алдагдлаар хаахаар ТУЗ шийдвэрлэсэн бол дутсан мөнгөний дүнгээр

Дебет: Бусад зардал

Кредит: Дутагдал

1-1.3 Бэлэн мөнгөний зузаатгал

ББСБ-ын салбар нэгж өөрийн төвдөө бэлэн мөнгө тушаавал салбар нь мөнгө хүргүүлэхдээ:

Дебет: Замд яваа мөнгө

Кредит: Бэлэн мөнгө

ББСБ-ын төвөөс ирүүлсэн бэлэн мөнгө хүлээн авсан баримтыг үндэслэн:

Дебет: Салбар хоорондын тооцоогоорх авлага

Кредит: Замд яваа мөнгө

ББСБ-ын төв нь:

Дебет: Касс дахь бэлэн мөнгө

Кредит: Салбар хоорондын тооцоогоорх өглөг

Салбар нь ББСБ-ын төвөөс бэлэн мөнгө татахад

ББСБ-ын төв нь мөнгө хүргүүлэхдээ:

Дебет: Замд яваа мөнгө

Кредит: Касс дахь бэлэн мөнгө

Салбараас ирүүлсэн бэлэн мөнгө хүлээн авсан баримтыг үндэслэн:

Дебет: Салбар хоорондын тооцоогоорх авлага
Кредит: Замд яваа мөнгө

Салбар нь хүлээн авсан бэлэн мөнгөний дүнгээр:

Дебет: Касс дахь бэлэн мөнгө
Кредит: Салбар хоорондын тооцоогоорх өглөг

1-1.4 Тоолж шалгаагүй бэлэн мөнгө

ББСБ нь салбараас тушаасан мөнгийг тоолж баталгаажуулах хүртэл Тоолж шалгаагүй бэлэн мөнгө дансанд бүртгэнэ.

Салбараас мөнгө тушаах үед дагалдах баримтад тусгасан дүнгээр:

Дебет: Тоолж шалгаагүй бэлэн мөнгө
Кредит: Салбар хоорондын тооцоогоорх өглөг

Тушаасан мөнгөний дүн дагалдах баримтын дүнтэй зөрүүгүй тохирсон нөхцөлд:

Дебет: Касс дахь бэлэн мөнгө
Кредит: Тоолж шалгаагүй бэлэн мөнгө

Тушаасан мөнгөнөөс дутвал:

Дебет: Салбар хоорондын тооцоогоорх авлага
Дебет: Касс дахь бэлэн мөнгө
Кредит: Тоолж шалгаагүй бэлэн мөнгө

Тушаасан мөнгөнөөс илүүдвэл, тэр дүнгээр:

Дебет: Касс дахь бэлэн мөнгө
Кредит: Салбар хоорондын тооцоогоорх өглөг
Кредит: Тоолж шалгаагүй бэлэн мөнгө

Б-1.2. БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГАД БАЙРШУУЛСАН МӨНГӨН ХӨРӨНГӨ

1. Хамрагдах зүйлс

Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгөд банк, санхүүгийн байгууллагад байршуулсан төгрөг, гадаад валютын харилцах, хадгаламжийн дансны үлдэгдэл орно.

2. Үнэлгээ

Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгийг нэрлэсэн үнээр нь бүртгэнэ. Гадаад валютыг Монголбанкны тухайн үеийн зарласан ханшаар тооцон төгрөг, гадаад

валютаар давхар бүртгэх ба ханшийн тэгшитгэлээс гарах орлого, зарлагыг тайлант хугацааны цэвэр орлого, зарлагад оруулан тооцно.

3. Санхүүгийн тайланд тусгах нь

Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгийг балансын Хөрөнгө талд Мөнгөн хөрөнгийн 2 дахь зүйл ангиар тусгана.

4. Хяналт ба бүртгэл

Банк, санхүүгийн байгууллагад эх үүсвэр байршуулах талаарх шийдвэрийг гаргах, хянах, банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тогтмол нийлж тохируулна.

Б-1.2. МӨНГӨН ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ

Банк, санхүүгийн байгууллагад харилцах, хадгаламж байршуулахад:

Дебет: Харилцах, хадгаламжийн холбогдох данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

Харилцах, хадгаламжид төлсөн хүүгийн орлогыг бүртгэхдээ:

Дебет: Харилцах, хадгаламжийн холбогдох данс
Кредит: Хүүгийн орлогын данс

Банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламжаас зарлагын гүйлгээ гарах буюу хаахад:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс
Кредит: Харилцах, хадгаламжийн данс

Б-2 БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

1. Тодорхойлолт

Хөрөнгө оруулалт гэж тайлант үед хийх төлбөрийн хэмжээнээс давсан илүүдэл мөнгөн хөрөнгийг ашиг олох зорилгоор зарцуулж буй үйл ажиллагааг хэлнэ. Хөрөнгө оруулалт нь түргэн борлогдох үнэт цаас ба урт хугацаат хөрөнгө оруулалтаас бүрдэнэ.

Түргэн борлогдох үнэт цаасанд ихэвчлэн богино хугацаат өмчийн үнэт цаас, бондын хөрөнгө оруулалт, арилжааны бичиг, засгийн газрын өрийн бичиг, хадгаламжийн сертификат зэрэг бусад богино хугацаат мөнгөн хөрөнгө оруулалт хамаарна.

Зах зээлийн үнэлгээний зөрүү болон хүүгээс ашиг олох зориулалтаар худалдан авсан арилжааны болон богино хугацаат хөрөнгө оруулалтын үнэт цаасыг Богино хугацаат хөрөнгө оруулалт гэнэ.

Арилжааны үнэт цаас гэж үнийн зөрүүгээс богино хугацаанд ашиг олох зорилгоор эзэмшиж буй үнэт цаасыг, хөрөнгө оруулалтын үнэт цаас гэж хүү болон ногдол ашгаас орлого олох, гол төлөв хугацаа нь дуустал эзэмшдэг үнэт цаасыг хэлнэ.

2. Үнэлгээ

Санхүүгийн тайланд түргэн борлогдох үнэт цаасаар хийсэн хөрөнгө оруулалтыг өртөг, зах зээлийн үнийн аль багаар бүртгэнэ. Худалдан авсан өдөр хөрөнгө оруулалтыг өртөгөөр нь бүртгэнэ.

Өртөг гэдэг нь үнэт цаасны худалдан авалтын үнэ, арилжаанд өгсөн хөрөнгийн зах зээлийн үнэ буюу шагнал, хандиваар хүлээн авсан үнэт цаасны үнэ дээр худалдан авалттай шууд холбоотой зардлыг нэмсэн дүн юм.

Арилжааны үнэт цаасыг борлуулснаас гарах орлого, зардлыг тайлант хугацааны цэвэр орлогод оруулна. Хөрөнгө оруулалтын үнэт цаасыг худалдан авсан өртгөөр нь бүртгэнэ.

Хөрөнгө оруулалтын үнэт цаасыг буцаан мөнгөжүүлэх үед гарах орлого, зардлыг тайлант хугацааны үнэт цаасны арилжааны орлого, зардлаар үзүүлнэ.

3. Санхүүгийн тайланд тусгах

Богино хугацаат хөрөнгө оруулалтыг хуулийн хувьд хүчин төгөлдөр гэрээ, хэлцлээр баталгаажсан нөхцөлд санхүүгийн тайлан тэнцэлд тусгана. Богино хугацаат хөрөнгө оруулалтыг балансын Хөрөнгө талд 2 дахь зүйл болгон тусгана.

Хөрөнгө оруулалтын үнэт цаасны зах зээлийн үнэлгээний талаар санхүүгийн тайланд тодруулга хийнэ. Үнэт цаасны эрсдэлийн санг холбогдох журмын дагуу байгуулж, санхүүгийн тайланд тодруулга хийнэ.

4. Үнэт цаасны эрсдэлийн сан

Хөрөнгө оруулалтын үнэт цаасны үнийн хэлбэлзлээс гарах эрсдэлийг тооцож, эрсдэлийн санг зардлаар байгуулна.

5. Хяналт ба бүртгэл

Гүйлгээний баримтын бүрдлийг хангаж үнэт цаасны нэр, төрлөөр дэлгэрэнгүй бүртгэл хөтөлнө. Дэлгэрэнгүй бүртгэлийг хяналтын дансны гүйлгээ, үлдэгдэлтэй тохируулна.

Үнэт цаасны бүртгэлийг үндсэн баримттай нь тулган шалгана. Үнэт цаасны хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангаж, биет байдлаар тоолж хяналт тавина.

Б-2.1 БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БҮРТГЭЛ

2.1 Үнэт цаас худалдан авах, худалдах

Үнэт цаас худалдан авахад:

Дебет: Үнэт цаасны холбогдох данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

Үнэт цаасыг буцаан худалдахад:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс
Кредит: Үнэт цаасны холбогдох данс

Үнэт цаасыг худалдахдаа бүртгэлийн үнээс зөрүүтэй үнээр борлуулсан зөрүүг үнэт цаасны арилжааны орлого, үнэт цаасны арилжааны алдагдлаар бүртгэнэ.

Ашигтай бол:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс
Кредит: Үнэт цаасны арилжааны орлого
Алдагдалтай бол:

Дебет: Үнэт цаасны арилжааны алдагдал
Кредит: Үнэт цаасны холбогдох данс

Үнэт цаасны хүүг хуримтлуулж бүртгэхэд:

Дебет: Хуримтлуулж тооцсон үнэт цаасны хүүгийн авлага
Кредит: Үнэт цаасны хүүгийн орлого

Үнэт цаасны хүү төлөгдөхөд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс
Кредит: Хуримтлуулж тооцсон үнэт цаасны хүүгийн авлага

Үнэт цаасны хүүг хуримтлуулж бүртгээгүй тохиолдолд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс
Кредит: Үнэт цаасны хүүгийн орлого

Арилжааны үнэт цаасны үнэлгээний тэгшитгэл хийх тохиолдолд дараах гүйлгээг хийнэ.

Үнэт цаасны бүртгэлийн үнэ, үнэлгээний тэгшитгэл хийх үеийн бодит үнэ цэнээс их байгаа бол:

Дебет: Арилжааны үнэт цаасны үнийн тохируулга
Кредит: Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого

Арилжааны үнэт цаасны бүртгэлийн үнэ, үнэлгээний тэгшитгэл хийх үеийн бодит үнэ цэнээс бага байгаа бол:

Дебет: Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн зардал

Кредит: Арилжааны үнэт цаасны үнийн тохируулга

Хөрөнгө оруулалтын үнэт цаасны бүртгэлийн үнэ, зах зээлийн үнээс зөрүүтэй тохиолдолд үнэлгээ хийж, үнэт цаасны хасагдуулга хийх буюу үнийн хэлбэлзлээс гарах эрсдэлийг тооцож, үнэт цаасны эрсдэлийн санг зардлаар байгуулна.

Үнэт цаасны эрсдэлийн санг байгуулахад:

Дебет: Үнэт цаасны эрсдэлийн зардал

Кредит: Үнэт цаасны эрсдэлийн сан

Үнэт цаасны эрсдэлийн сангаар үнэлгээг хорогдуулахад:

Дебет: Үнэт цаасны эрсдэлийн сан

Кредит: Үнэт цаасны холбогдох данс

2.2 Үнэт цаасны хорогдуулаагүй нэмэгдүүлэлт ба хямдруулалт

Үнэт цаасыг нэрлэсэн үнээс илүү үнээр худалдаж (нэмэгдэлтэй) авахад:

Дебет: Үнэт цаасны холбогдох данс (нэрлэсэн үнээр)

Дебет: Үнэт цаасны хорогдуулаагүй нэмэгдэл (үнийн зөрүүгээр)

Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

ББСБ үнэт цаасны хүүг тайлант үеийн эцэст хуримтлуулж тооцно. Ингэхдээ нийт хүүгийн дүнгээр авлагыг бүртгэх боловч нэмэгдсэн үнийн зөрүүгийн тайлант хугацаанд ногдох дүнгээр хүүгийн орлогыг хорогдуулна.

Дебет: Хуримтлуулж тооцсон үнэт цаасны хүүгийн авлага (нэрлэсэн хүүгийн дүнгээр)

Кредит: Үнэт цаасны хорогдуулаагүй нэмэгдэл (тайлант хугацаанд ногдох нэмэгдлийн дүнгээр)

Кредит: Үнэт цаасны хүүгийн орлого (нэрлэсэн хүү - тайлант хугацаанд ногдох нэмэгдлийн дүн)

Үнэт цаасны хүү төлөгдөхөд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс

Кредит: Хуримтлуулж тооцсон үнэт цаасны хүүгийн авлага буюу урьд нь хуримтлуулаагүй хүү төлөгдөхөд

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс

Кредит: Үнэт цаасны хорогдуулаагүй нэмэгдэл (харгалзах нэмэгдлийн дүнгээр)

Кредит: Үнэт цаасны хүүгийн орлого (нэрлэсэн хүү-харгалзах нэмэгдлийн дүн)

Үнэт цаасыг буцаан худалдахад:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс

Кредит: Үнэт цаасны холбогдох данс (нэрлэсэн үнээр)

Нэмэгдүүлсэн үнээр худалдан авсан үнэт цаасны үнийн нэмэгдлийг орлогод шингээж дуусаагүй нөхцөлд худалдвал:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс
Кредит: Үнэт цаасны холбогдох данс (нэрлэсэн үнээр)
Кредит: Үнэт цаасны хорогдуулаагүй нэмэгдэл (нэмэгдлийн үлдсэн дүнгээр)

Үнэт цаасыг нэрлэсэн үнэ буюу хорогдуулаагүй нэмэгдлийг тооцсон дүнгээс зөрүүтэй үнээр худалдвал үнийн зөрүүг тайлант үеийн ашиг, алдагдалд бүртгэнэ.

Үнэт цаасыг ББСБ нэмэгдэлтэй худалдан авсан тохиолдлыг жишээгээр авч үзье.

Жишээ: 2003 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр ББСБ жилийн 5 хувийн нэрлэсэн хүүтэй 1,000,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй Засгийн газрын өрийн бичгийг жилийн 4 хувийн зах зээлийн хүүгээр бодож 1,009,787 төгрөгийн нэмэгдэлтэйгээр худалдан авав. Засгийн газрын өрийн бичиг нь 2004 оны 4 дүгээр сарын 30, 10 дугаар сарын 31-ний өдрүүдэд хүүгээ төлнө. Засгийн газрын өрийн бичиг нь 2004 оны 10 дугаар сарын 31-ний өдөр эргэж төлөгдөнө.

ББСБ нь 2003 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр дараах бичилтүүд хийнэ. Үүнд:

Дебет: Засгийн газрын үнэт цаас 1,000,000 Г
Дебет: Үнэт цаасны хорогдуулаагүй нэмэгдэл 9,787 Г
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох дансд 1,009,787 Г

11 дүгээр сарын хүү $1,000,000 * 0.05 : 12 = 4,167/-$ г хуримтлуулан тооцож;

Дебет: Хуримтлуулж тооцсон үнэт цаасны хүүгийн авлага 4,167 Г
Кредит: Үнэт цаасны хорогдуулаагүй нэмэгдэл 801 Г
Кредит: Засгийн газрын үнэт цаасны хүүгийн орлого 3,366 Г

Засгийн газар үнэт цаасныхаа эхний 6 сарын хүүнд нийт 25,002 /сарын хүүгийн орлого 4,167*6 сар/ төгрөгийг 2004 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр төлсөн тохиолдолд;

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох дансд
Кредит: Хуримтлуулж тооцсон Засгийн газрын үнэт цаасны хүүгийн авлага

Дээрх аргаар сүүлийн 6 сарын хүүг хуримтлуулан тооцож, 2004 оны 10 дугаар сарын 31-ний өдөр өрийн бичгийн нэрлэсэн үнэ /1,000,000 Г/-ийг хүү /25,002 Г/-гийн хамт Засгийн Газраар төлүүлнэ.

Доорх хүснэгтийг үндэслэн сар бүр нэмэгдлийн хорогдлоор Засгийн газрын үнэт цаасны орлогыг хорогдуулан бүртгэнэ.

Үнэт цаасны нэмэгдлийг хорогдуулах хүснэгт

№	Он сар өдөр	Нэрлэсэн хүүгийн орлого	Хүүгийн орлого	Нэмэгдлийн хорогдол	Худалдан авсан өртөг	Хорогдуулаагүй нэмэгдэл
1	11.01.2003				1,009,787	9.787
2	11.30.2003	4.167	3.366	801	1,008,986	8.986
3	12.31.2003	4.167	3.363	803	1,008,183	8.183
4	01.31.2004	4.167	3.361	806	1,007,377	7.377
5	02.28.2004	4.167	3.358	809	1,006,568	6.568
6	03.31.2004	4.167	3.355	811	1,005,757	5.757
7	04.30.2004	4.167	3.353	814	1,004,943	4.943
8	05.31.2004	4.167	3.350	817	1,004,126	4.126
9	06.30.2004	4.167	3.347	820	1,003,306	3.306
10	07.31.2004	4.167	3.344	822	1,002,484	2.484
11	08.31.2004	4.167	3.342	825	1,001,659	1.659
12	09.30.2004	4.167	3.339	828	1,000,831	831
13	10.31.2004	4.167	3.336	831	1,000,000	-
	ДҮН			9.787		

Тайлбар: Хүүгийн орлогыг тооцохдоо үнэт цаасны урьд сарын үнийг 0,04-өөр үржүүлж 12 сард хуваана.

Тухайлбал: 11 дүгээр сарын нэмэгдлийн хорогдол нь:
 $4,167 - (1,009,787 * 0.04 / 12) = 801$ төгрөг болно.

Хөрөнгө оруулалтын үнэт цаасыг нэрлэсэн үнээс бага үнээр худалдаж (хямдруулалттай) авахад

Дебет: Үнэт цаасны холбогдох данс (нэрлэсэн үнээр)
 Кредит: Үнэт цаасны хорогдуулаагүй хямдрал (үнийн зөрүүгээр)
 Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

ББСБ үнэт цаасны хүүг тайлант хугацаанд хуримтлуулж тооцно. Ингэхдээ нийт хүүгийн дүнгээр авлагыг бүртгэх боловч, хямдруулсан үнийн зөрүүгийн тайлант хугацаанд ногдох дүнгээр хүүгийн орлогыг нэмэгдүүлнэ.

Дебет: Хуримтлуулж тооцсон үнэт цаасны хүүгийн авлага (нэрлэсэн хүү)
 Дебет: Үнэт цаасны хорогдуулаагүй хямдрал (хямдруулалтын тайлант үед ногдох дүн)
 Кредит: Үнэт цаасны хүүгийн орлого (нэрлэсэн хүү+хямдруулалтын тухайн тайлант үед ногдох дүн)

Үнэт цаасны хүү төлөгдөхөд

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс
 Кредит: Хуримтлуулж тооцсон үнэт цаасны хүүгийн авлага буюу урьд нь хуримтлуулаагүй хүү төлөгдөхөд

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс (нэрлэсэн хүү)

Дебет: Үнэт цаасны хорогдуулаагүй хямдрал (хямдруулалтын тухайн хугацаанд ногдох дүн)

Кредит: Үнэт цаасны хүүгийн орлого (нэрлэсэн хүү+хямдруулалтын тухайн хугацаанд ногдох дүн)

Үнэт цаасыг буцаан худалдахад

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс

Кредит: Үнэт цаасны холбогдох данс (нэрлэсэн үнээр)

Хямдруулалттай худалдан авсан үнэт цаасны үнийн хямдруулалтыг орлогод шингээж дуусаагүй нөхцөлд худалдвал

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс

Дебет: Үнэт цаасны хорогдуулаагүй хямдрал

Кредит: Үнэт цаасны холбогдох данс (нэрлэсэн үнээр)

Үнэт цаасыг нэрлэсэн үнэ буюу хорогдуулаагүй хямдруулалтыг тооцсон дүнгээс зөрүүтэй үнээр худалдвал үнийн зөрүүг тайлант үеийн ашиг, алдагдалд бүртгэнэ.

Үнэт цаасыг ББСБ хямдруулалттай үнээр худалдан авсныг жишээгээр авч үзье.

Жишээ: 2003 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр ББСБ жилийн 5 хувийн нэрлэсэн хүүтэй 1,000,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй Засгийн газрын өрийн бичгийг жилийн 6 хувийн зах зээлийн хүүгээр бодож 990,318 төгрөгөөр хямдруулалттай худалдан авав. Засгийн Газрын өрийн бичгийн хүүг 2004 оны 4 дүгээр сарын 30, 10 дугаар сарын 31-ний өдрүүдэд төлнө. Засгийн газрын өрийн бичиг нь 2004 оны 10 дугаар сарын 31-ний өдөр эргэж төлөгдөнө.

ББСБ дээр 2003 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр дараах бичилтүүд хийгдэнэ. Үүнд:

Дебет: Засгийн газрын үнэт цаас 1,000,000 Г

Кредит: Үнэт цаасны хорогдуулаагүй хямдрал 9,682 Г

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох дансд 990,318 Г

ББСБ 11 дүгээр сарын хүү $1,000,000 * 0.05 : 12 = 4,167/-$ г хуримтлуулан тооцож:

Дебет: Хуримтлуулж тооцсон Засгийн газрын үнэт цаасны хүүгийн авлага 4,167 Г

Дебет: Үнэт цаасны хорогдуулаагүй хямдрал 785 Г

Кредит: Засгийн газрын үнэт цаасны хүүгийн орлого 4,952Г

Засгийн газар үнэт цаасныхаа эхний 6 сарын хүүд нийт 25,002 /сарын хүүгийн орлого 4167*6 сар/ төгрөгийг 2001 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр төлсөн тохиолдолд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох дансд

Кредит: Хуримтлуулж тооцсон ЗГ-ын үнэт цаасны хүүгийн авлага

Дээрх аргаар ББСБ өрийн бичгийн сүүлийн 6 сарын хүүг хуримтлуулан тооцож, 2004 оны 10 дугаар сарын 31-ний өдөр өрийн бичгийн нэрлэсэн үнэ /1,000,000Г/-ийг хүү /25,002/-гийн хамт Засгийн газраар төлүүлнэ.

Доорх хүснэгтийг үндэслэн сар бүр хямдруулалтын хорогдлоор Засгийн газрын үнэт цаасны орлогыг нэмэгдүүлэн бүртгэнэ.

Үнэт цаасны хямдруулалтыг хорогдуулах хүснэгт

№	Он сар өдөр	Нэрлэсэн хүүгийн орлого	Хүүгийн орлого	Нэмэгдлийн хорогдол	Худалдан авсан өртөг	Хорогдуулаагүй нэмэгдэл
1	11.01.2003				990,318	9,682
2	11.30.2003	4.167	4.952	785	991,102	8,898
3	12.31.2003	4.167	4.956	789	991,891	8,109
4	01.31.2004	4.167	4.959	793	992,684	7,316
5	02.28.2004	4.167	4.963	797	993,481	6,519
6	03.31.2004	4.167	4.967	801	994,282	5,718
7	04.30.2004	4.167	4.971	805	995,086	4,914
8	05.31.2004	4.167	4.975	809	995,895	4,105
9	06.30.2004	4.167	4.979	813	996,708	3,292
10	07.31.2004	4.167	4.984	817	997,585	2,475
11	08.31.2004	4.167	4.988	821	998,346	1,654
12	09.30.2004	4.167	4.992	825	999,171	829
13	10.31.2004	4.167	4.996	829	1,000,000	-
	Дүн			<u>9,682</u>		

Тайлбар: Хүүгийн орлогыг тооцоходоо үнэт цаасны урд сарын үнийг 0.06-аар үржүүлж 12 сард хуваана.

Тухайлбал: 11 дүгээр сарын хямдруулалтын хорогдол нь

$$/990318 * 0.06 / 12 / - 4167 = 785 \text{ төгрөг болно.}$$

Б-3 ЗЭЭЛ

1. Тодорхойлолт

Зээл гэж ББСБ-аас тодорхой зориулалт, хүү, хугацаа, эргэж төлөгдөх нөхцөл, барьцаа, батлан даалттайгаар мөнгөн хөрөнгийг өөрийн нэрийн өмнөөс бусад этгээдэд зээлдүүлэх үйл ажиллагааг хэлнэ.

Зээлийн зүйл ангид төлбөрийн хэрэгслийг ашигласны үр дүнд иргэд, байгууллагаас авах авлага (картын зээл г.м)-ыг хамруулна.

Зээлийн хүү гэдэг нь гэрээнд заасан хэмжээгээр зээлийг ашигласны үнийг хэлнэ.

2. Зээлийн эрсдэлийн сан

Олгосон зээлийг хугацаа, чанар, эргэж төлөгдөх магадлалыг нь харгалзан ангилах замаар Зээлийн эрсдэлийн санг /цаашид ЗЭС сан гэх/ тооцож зардлаар байгуулна.

3. Үнэлгээ ба орлогын бүртгэл

Зээлийг олгосон дүнгээр нь бүртгэнэ. Зээл нь урьдчилан тооцсон цэвэр боломжит хэмжээгээр үнэлэгдэнэ. Зээлийн цэвэр дүн нь өрийн үлдэгдлээс түүнд байгуулсан ЗЭС-г хассан дүн байна. Гадаад валютаар олгосон зээлийг Монголбанкнаас зарласан ханшаар тооцож төгрөгт хөрвүүлэн төгрөг, гадаад валютаар давхар бүртгэх ба ханшийн хэлбэлзлээс гарах орлого, зарлагыг тайлант хугацааны цэвэр орлогод тусгана.

Гадаад валютаар олгосон зээл чанаргүй зээлд ангилагдсан үед ханшийн тэгшитгэл хийвэл ханш өсч, буурсан хэмжээгээр зээлийн эрсдэлийн сангийн хэмжээнд өөрчлөлт оруулна.

ББСБ зээлийн хүүгийн орлогыг нягтлан бодох бүртгэлийн хуримтлуулан тооцох зарчмаар бүртгэнэ. Өөрөөр хэлбэл тайлант хугацаанд ногдох хүүгийн орлогыг мөнгөөр төлөгдсөн эсэхээс үл хамааруулж орлогод бүртгэнэ. Зээлийн хүүг холбогдох хууль тогтоомж, заавар журам болон зээлийн гэрээний дагуу тооцно.

4. Санхүүгийн тайланд тусгах нь:

Зээлийг балансын Хөрөнгө талд 3 дахь зүйл болгон тусгана. Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлагыг Бусад активын бүлэгт, хуримтлуулж тооцохыг зогсоосноос хойш тэнцлийн гадуурх Хуримтлуулж тооцохыг зогсоосон зээлийн хүүгийн дансанд бүртгэнэ.

Хуримтлуулж тооцсон хүүгийн авлагыг тайлант хугацааны орлогод оруулна. Хуримтлуулж тооцохыг зогсоосон зээл, хүүгийн орлогын талаар санхүүгийн тайланд тодруулна.

ББСБ-ын төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, бусад ажилтан болон тэдгээрт холбогдох этгээдэд олгосон зээлийн талаар санхүүгийн тайланд тодруулна.

5. Хяналт ба бүртгэл .

Зээлдэгч бүрээр дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж, дэлгэрэнгүй бүртгэлийг дансны гүйлгээ, үлдэгдэлтэй тохируулна. Зээлийн барьцаа, батлан даалт, холбогдох баримт материал, зээлийн хувийн хэргийг бүрдүүлж найдвартай орчинд хадгална. Зээлийн барьцаа хөрөнгийн биет байдалд байнгын хяналт тавина.

Зээлийг холбогдох журмын дагуу ангилж бүртгэн, эрсдэлийн санг шаардлагатай хэмжээнд байгуулсан байдалд хяналт тавина. Тайлант үеийн эцсээр зээлийн үндсэн өр болон хүүгийн авлагыг зээлдэгчтэй тулган баталгаажуулна.

Б-3.1 ЗЭЭЛИЙН БҮРТГЭЛ

3.1 Зээл олгох, төлүүлэх

Зээл олгоход:

Дебет : Зээлийн холбогдох данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

Зээлдэгч зээлийн үндсэн өрийг эргүүлэн төлөхөд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс
Кредит: Зээлийн холбогдох данс

3.2 Зээлийн хүүгийн бүртгэл

Зээлийн гэрээнд заасан хувь хэмжээгээр хүүгийн орлогыг хуримтлуулж бүртгэхэд:

Дебет: Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага
Кредит: Зээлийн хүүгийн орлого

Хуримтлуулж бүртгэсэн зээлийн хүүг зээлдэгч төлөхөд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс
Кредит: Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага

Тухайн тайлант үед ногдох, өмнө нь хуримтлуулж бүртгээгүй хүү төлөгдөхөд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Зээлийн хүүгийн орлого

Зээлийн үндсэн өр, хүүгийн төлбөрийн аль нэг нь зээлийн гэрээнд заагдсан төлөгдөх хугацаанаас хойш 90 хоногийн дотор төлөгдөөгүй бол 91 дэх хоногоос эхлэн хүүг хуримтлуулж бүртгэхийг зогсоож, өмнө нь хуримтлуулсан хүүг буцаана. Хуримтлуулсан хүүг буцаахдаа сөрөг утгатай Хүүгийн орлогын буцаалтын дансыг хэрэглэнэ.

Дебет: Хүүгийн орлогын буцаалт
Кредит: Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага

Буцаасан хүүгийн дүнгээр тэнцлийн гадуурх Хуримтлуулж тооцохыг зогсоосон зээлийн хүүгийн дансанд бүртгэж, цаашид тухайн зээлд тооцох хүүг энэ дансанд нэмж бүртгэн, төлүүлэх арга хэмжээг үргэлжлүүлнэ.

Тэнцлийн гадуур бүртгэлтэй хүү төлөгдөхөд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс
Кредит: Зээлийн хүүгийн орлого

Төлөгдсөн хүүгийн дүнгээр тэнцлийн гадуурх данснаас зарлагадана.

3.3 Зээлийн ангилал, ЗЭС байгуулах, зарцуулах

ББСБ холбогдох журмын дагуу зээлээ ангилж, тухайн ангиллын дансаар бүртгэнэ.

Журамд заасны дагуу зээл хугацаа хэтэрсэн тохиолдолд уг зээлийг “Хэвийн” ангиллаас “Хугацаа хэтэрсэн” ангилалд шилжүүлэн дараах бичилт хийнэ.

Дебет: Хугацаа хэтэрсэн зээл
Кредит: Хэвийн зээл

Зээлийн чанар сайжирч, ангилал дээшлүүлэхэд эсрэг гүйлгээ хийнэ.

ББСБ зээлийн ангилалд тохирсон Зээлийн эрсдэлийн санг тайлант хугацааны зардлаар байгуулна. ЗЭС байгуулах ББСБ-ын бодлого нь эрх бүхий байгууллагын баталсан холбогдох журмаар тогтоосон зарчмаас өөр бол эрсдэлийн зардлын зөрүүг санхүүгийн тайланд тодруулна.

ЗЭС байгуулахад:

Дебет: Зээлийн эрсдэлийн зардал
Кредит: Зээлийн эрсдэлийн сан

Хэрэв ЗЭС шаардлагатай хэмжээнээс илүү бол:

Дебет: Зээлийн эрсдэлийн сан
Кредит: Зээлийн эрсдэлийн зардал

Хэрэв буцаах дүн эрсдэлийн зардлын дүнгээс илүү бол зөрүү дүнгээр тайлант хугацааны орлого болгож:

Дебет: Зээлийн эрсдэлийн сан
Кредит: Бусад орлого

ЗЭС-аас зээл хаахад:

Дебет: Зээлийн эрсдэлийн сан
Кредит: Зээлийн холбогдох данс

Хаасан зээлийн дүнгээр тэнцлийн гадуурх ЗЭС-аас хаасан зээлийн дансанд бүртгэж, зээлийг эргүүлж төлүүлэх ажиллагааг үргэлжлүүлнэ.

Хаасан зээл эргэж төлөгдөхөд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс
Кредит: Бусад орлого

Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн өөрчлөлтөөс гадаад валютаар олгосон зээлийн багцын дүн өөрчлөгдвөл ЗЭС-ийн зөрүүг зээлийн эрсдэлийн зардлаар тохируулна.

Гадаад валютын ханш өссөнөөс зээлийн багцын дүн өсвөл:

Дебет: Зээлийн эрсдэлийн зардал
Кредит: Зээлийн эрсдэлийн сан

Гадаад валютын ханш буурснаас зээлийн багцын дүн буурвал:

Дебет: Зээлийн эрсдэлийн сан
Кредит: Зээлийн эрсдэлийн зардал

3.4 Зээлийн барьцаа, батлан даалтын хөрөнгө

Зээлийн барьцаанд авсан эд хөрөнгө болон эд хөрөнгийг эзэмших эрхийг тэнцлийн гадуурх Зээлийн барьцаа хөрөнгийн дансанд орлогодож, зээлдэгч зээлийг бүрэн төлсөн нөхцөлд тухайн данснаас зарлагадана.

ББСБ нь гуравдагч хуулийн этгээдээс гаргасан батлан даалтыг үндэслэн зээл олгож болно. Гуравдагч хуулийн этгээд батлан даалтын эх үүсвэрт мөнгөн хөрөнгө байршуулсан бол ББСБ нь дараах бүртгэлийн бичилтийг хийнэ. Үүнд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс
Кредит: Зээлийн батлан даалтанд байршуулсан эх үүсвэр

Зээлдэгч зээлийн гэрээний үүргээ бүрэн биелүүлж, ББСБ батлан даалтад байршуулсан эх үүсвэрийг гуравдагч этгээдэд буцааж олговол:

Дебет: Зээлийн батлан даалтанд байршуулсан эх үүсвэр
Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

Зээлдэгч зээл болон зээлийн хүүг төлж барагдуулаагүй бол батлан даалтын эх үүсвэрт байршуулсан хөрөнгөөс холбогдох төлбөрийг хийнэ.

Дебет: Зээлийн батлан даалтанд байршуулсан эх үүсвэр
Кредит: Зээлийн холбогдох данс, Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага буюу орлого

ББСБ харилцагчийн нэрийн өмнөөс зээлийн батлан даалт гаргаж болно. Батлан даалтын хугацаа дуусч, харилцагч зээлээ төлж чадаагүйгээс ББСБ зээлийг төлж барагдуулах нөхцөлд зээлийн төлбөрийг хийхийн өмнө зээлийн хувийн хэрэг, төлбөр тооцоо хийсэн баримт болон холбогдох баримт материалыг тухайн зээлийг олгосон ББСБ-аас эх хувиар нь гаргуулан хүлээн авсаны эцэст тайлан, тэнцэлд зээл болгон бүртгэнэ.

Дебет: Зээлийн холбогдох данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

Харилцагч зээлийг буцааж төлөхөд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс
Кредит: Зээлийн холбогдох данс

Б-4 САНХҮҮГИЙН ТҮРЭЭС

1. Тодорхойлолт

ББСБ нь тодорхой нөхцөл, хугацаа, төлбөртэйгээр түрээслэгчийн буюу сонгосон эд хөрөнгийг өөрөө үйлдвэрлэх, эсвэл худалдагч буюу нийлүүлэгчээс өөрийн нэр дээр худалдан

авах замаар түрээслэх үйл ажиллагаа юм. Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаанд түрээслэгч, нийлүүлэгч талууд оролцоно.

2. Шалгуур үзүүлэлт

1.Түрээслүүлэгч нь хөрөнгийн өмчлөх эрхийг түрээслэгчид шилжүүлэх,

2.Түрээслэгч нь худалдан авах сонголтоо хийж түрээслүүлэгчтэй харилцан тохиролцсон гэрээ хийсэн байх,

3. Түрээсийн хугацаа нь уг түрээслэсэн хөрөнгийн тооцоолсон үр ашигт хугацааны 75-аас дээш хувьтай тэнцүү байх,

4. Түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнэ нь уг түрээслүүлсэн хөрөнгийн зах зээлийн үнийн 90-ээс дээш хувьтай байх

3. Санхүүгийн түрээсийн гэрээ

Түрээсийн гэрээ гэдэг нь түрээслэх хөрөнгийг санхүүгийн түрээсээр олгосон өдрөөс санхүүгийн түрээсийн хугацаа дуусах өдрийг хүртэл түрээслэгч, түрээслүүлэгч нарын хооронд байгуулсан хуулийн хүчин төгөлдөр баримтыг хэлнэ.

Гэрээнд оролцогч байгууллагууд нь өөрийн хүлээх хариуцлага, эрх үүргийг тодорхой тусгасан байна.

4. Үнэлгээ ба орлогын бүртгэл

Санхүүгийн түрээсээр өгсөн хөрөнгийг санхүүгийн тайланд түрээсийн цэвэр хөрөнгө оруулалттай тэнцүү дүнгээр санхүүгийн түрээсийн авлага гэж бүртгэнэ.

Үндсэн хөрөнгийн ирээдүйн болон өнөөгийн үнэ цэнийг тооцон үзэж авлага, орлогын хэмжээг санхүүгийн түрээсийн үлдэгдлээр бүртгэлд тусгана.

Санхүүгийн түрээсийн хүүгийн авлагыг Бусад активын бүлэгт, хүүгийн орлогыг хойшлогдсон хүүгийн орлогоор бүртгэн пассив бүлэгт үзүүлэх ба тайлант хугацаанд үр ашигт хүүгийн аргаар элэгдүүлнэ.

5. Санхүүгийн тайланд тусгах нь

Санхүүгийн түрээсийн авлагыг тэнцлийн Хөрөнгө талд 4 дэх зүйл болгон тусгана.

Санхүүгийн түрээсийн эрсдлийн санг зээлийн адил ангилж, байгуулан эрсдлийн сангийн хэмжээгээр цэвэрлэж үзүүлнэ.

Б-4.1 САНХҮҮГИЙН ТҮРЭЭСИЙН БҮРТГЭЛ

Түрээсийн гэрээгээр хөрөнгийг шилжүүлэх үед өнөөгийн үнэ цэнээр

Дебет: Санхүүгийн түрээсийн авлага

Кредит: Үндсэн хөрөнгө /Түрээслэсэн хөрөнгийн төрлөөр/

Санхүүгийн түрээсийн хүүг хуримтлуулан тооцож

Дебет: Хуримтлуулсан санхүүгийн түрээсийн хүүгийн авлага

Кредит: Санхүүгийн түрээсийн хүүгийн орлого

Түрээс, хүүгийн төлбөрийг авах үед

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох дансд

Кредит: Санхүүгийн түрээсийн авлага

Кредит: Хуримтлуулсан санхүүгийн түрээсийн хүүгийн авлага

Түрээсийн хугацааны эцэст түрээслэсэн хөрөнгөө түрээслэгч талд илүү үнээр борлуулсан бол

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Үндсэн хөрөнгө борлуулалтын олз.

Түрээслэгчийн бүртгэл:

Түрээсийн гэрээгээр хөрөнгийг хүлээн авах үед

Дебет: Үндсэн хөрөнгө /Түрээслэн авсан хөрөнгийн төрлөөр/

Кредит: Санхүүгийн түрээсийн өглөг

Санхүүгийн түрээсийн хүүг хуримтлуулан тооцож

Дебет: Санхүүгийн түрээсийн хүүгийн зардал

Кредит: Хуримтлуулж тооцсон санхүүгийн түрээсийн хүүгийн өглөг

Түрээс, хүүгийн төлбөрийг төлөх үед

Дебет: Санхүүгийн түрээсийн өглөг

Дебет: Хуримтлуулж тооцсон санхүүгийн түрээсийн хүүгийн өглөг

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох дансд

Санхүүгийн түрээсийн авлагыг зээлийн нэгэн адил ангилж эрсдлийн сан байгуулна.

Б-5 ФАКТОРИНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

1. Тодорхойлолт

Факторингийн үйлчилгээ гэж зээлдүүлэгч буюу үүрэг гүйцэтгүүлэгчээс мөнгөн төлбөрийн үүргийг шаардах эрхээ гуравдагч этгээдэд бүхэлд нь /шилжүүлэх/, энэхүү эрхийг хүлээн авагч нь эрхээ хэрэгжүүлэх болон үүсэн гарах үр дагаврыг бүрэн хариуцах үйл ажиллагааг ойлгоно.

2. Факторингийн үйлчилгээний гэрээ

Нийлүүлэгч болон факторинг эрхлэгчийн хүлээх эрх, үүрэг, хамрах хүрээ, оролцогч талуудын харилцан тохиролцсон шаардлага хангахуйц баримт бичиг, өр төлбөрийг худалдаж авах хэлбэр, хугацаа, үнэ зэргийг факторингийн үйлчилгээний гэрээнд тусгана.

3. Үнэлгээ ба орлогын бүртгэл

Факторингийн авлагыг үндсэн өрийн үлдэгдлийн дүнгээр бүртгэнэ. Факторингийн тооцооны авлагын хүүг хуримтлуулж тооцно. Факторингийн авлагын эрсдэлийн санг байгуулсан дүнгээр тусад нь бүртгэнэ.

4. Санхүүгийн тайланд тусгах

Факторингийн авлагыг тэнцлийн Хөрөнгө талд 5 дахь зүйл болгон тусгана.

Факторингийн авлагыг зээлийн адил ангилан эрсдэлээс хамгаалах сан байгуулан тэр хэмжээгээр цэвэршүүлж үзүүлнэ.

Хуримтлуулж тооцсон факторингийн хүүгийн авлагыг Бусад активын бүлэгт, хуримтлуулж тооцохыг зогсоосноос хойш тооцсон хүүгийн авлагыг тэнцлийн гадуурх Хуримтлуулж тооцохыг зогсоосон факторингийн хүүгийн дансанд тусгана. Хуримтлуулж тооцсон хүүгийн авлагыг тайлант хугацаанд төлүүлнэ.

5. Хяналт ба бүртгэл

Барьцаа, батлан даалт, холбогдох баримт материал, зээлийн хувийн хэргийг заавал эх хувиар бүрдүүлж хадгалж хамгаалах ба биет байдалд тогтмол хяналт тавина.

Факторингийн авлагын талаар санхүүгийн тайланд тодруулга хийнэ.

Факторингийн авлага тус бүрээр дэлгэрэнгүй бүртгэл хөтлөж, дансны үлдэгдлийг тогтмол нийлж тохируулна.

Б-5.1 ФАКТОРИНГИЙН БҮРТГЭЛ

ББСБ нь авлагыг хямдруулан худалдаж авах, нийлүүлэгчийн тэнцлийн дүн дээр хүү тооцохоор харилцан тохиролцон гэрээ байгуулан худалдан авч болно. Худалдан авсан авлагыг гэрээнд яаж тохиролцсоноос болж үе шаттайгаар хэрэгжүүлж болно.

5.1 Факторингийн авлагын бүртгэл

ББСБ ямар нэгэн хуулийн этгээдийн авлагыг хямдруулан худалдаж авсан бол:

Дебет: Факторингийн тооцоогоор үүссэн авлага

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Хямдруулан худалдаж авсан факторингийн авлагын хэрэгжилт:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Факторингийн тооцоогоор үүссэн авлага

ББСБ нь авлагыг хямдруулан худалдаж авсан ч авлага үүсгэж байгаа байгууллагатай гэрээ хийж зээлтэй ижил факторингийн үйлчилгээний авлагын хүү тооцон авч болно.

Дебет: Хуримтлуулж тооцсон факторингийн үйлчилгээний хүүгийн авлага
Кредит: Факторингийн үйлчилгээний хүүгийн орлого

Хуримтлуулж тооцсон факторингийн үйлчилгээний хүүг төлөхөд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Хуримтлуулж тооцсон факторингийн үйлчилгээний хүүгийн авлага

Худалдаж авсан факторингийн авлагын хэрэгжилт:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Факторингийн тооцоогоор үүссэн авлага

5.2 Факторингийн тооцоогоор үүссэн авлагын ангиллыг өөрчлөх

Факторингийн тооцоогоор үүссэн авлагын ангиллыг зохих журмын дагуу өөрчилж болно. Энэ нөхцөлд факторингийн тооцоогоор үүссэн авлагыг тайлант үеийн ангиллын данснаас журмаар шинэчлэн тогтоогдсон ангиллын дансанд шилжүүлэн бичнэ. Тухайлбал, факторингийн авлагыг хэвийн ангиллаас хугацаа хэтэрсэн ангилалд шилжсэнийг бүртгэхдээ:

Дебет: Хугацаа хэтэрсэн факторингийн тооцооны авлага
Кредит: Хугацаандаа байгаа факторингийн тооцооны авлага

5.3 Факторингийн авлагын эрсдэлийн сан /ФАЭС/-ийн бүртгэл

ФАЭСанг ангиллын хувь хэмжээгээр эрсдэлийн зардлаар байгуулан зохих дансанд бүртгэнэ. Үүнд:

Дебет: Факторингийн авлагын эрсдэлийн зардал
Кредит: Факторингийн авлагын эрсдэлийн сан

ФАЭС-аас чанаргүй болсон факторингийн үйлчилгээний авлагыг хаах нөхцөлд:

Дебет: Факторингийн авлагын эрсдэлийн сан
Кредит: Факторингийн үйлчилгээний авлагын холбогдох данс

ФАЭСангаас хаасан дүнгээр факторингийн үйлчилгээний авлагыг холбогдох баримт материалын хамт тэнцлийн гадуурх факторингийн үйлчилгээний дансанд орлого болгон бүртгэж, авлагыг барагдуулах үйл ажиллагааг үргэлжлүүлнэ.

ФАЭС-аас хаасан авлага эргэж төлөгдөхөд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Б-6 ӨМЧЛӨХ БУСАД ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ

1. Тодорхойлолт

Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө гэж зөвхөн зээл төлөлтийн тооцоогоор (зээлдэгчээс зээлийн барьцаанд тавьсан үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах зорилгоор хураан авсан хөрөнгө) бусдаас өмчлөн авахад хүрсэн, ББСБ-ын үйл ажиллагаанд хамааралгүй үл хөдлөх хөрөнгийг хэлнэ.

2. Үнэлгээ

Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө (ӨБҮХХ)-ийг борлуулах зах зээлийн үнэлгээ нь зээлийн дүнгээс бага байвал аль багаар нь тэнцэлд бүртгэнэ.

ӨБҮХХ-ийг борлуулахад гарах ашиг, алдагдлыг тухайн тайлант хугацааны цэвэр орлого, зарлагад оруулна.

ӨБҮХХ-ийн зах зээлийн үнэлгээний хэлбэлзлээс гарч болзошгүй алдагдлыг эрсдэлийн сангаас байгуулна.

3. Санхүүгийн тайланд тусгах нь

Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийг балансын Хөрөнгө талд 6 дахь зүйл болгон тусгана.

ӨБҮХХ-ийг зохих журмын дагуу ангилан түүнд байгуулсан эрсдэлийн сангаар цэвэршүүлсэн ББСБ-ын тэнцэлд тусгана.

4. Хяналт ба бүртгэл

ӨБҮХХ-ийн бүртгэлийг үндсэн баримттай нь тулган шалгаж, дэлгэрэнгүй бүртгэлийг хяналтын дансны гүйлгээ үлдэгдэлтэй тохируулна.

ББСБ-ын Дотоод хяналтын алба нь Зээлийн хороо болон бусад эрх бүхий этгээд ӨБҮХХ-ийн үнэлгээг зах зээлийн үнэлгээтэй уялдуулан бодитойгоор тогтоосон болон өмчилж авсан хөрөнгийг урт хугацаанд борлуулж тооцоог дуусгавар болгож байгаа эсэхэд тогтмол хяналт тавина. ӨБҮХХ-ийн талаар санхүүгийн тайланд тодруулга хийнэ.

Б-6.1 ӨМЧЛӨХ БУСАД ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ

Зээлийн өрийн үлдэгдлийг барагдуулах зорилгоор ББСБ зээлдэгчтэй байгуулсан гэрээнд барьцаа болгон заасан хөрөнгийн өмчлөх эрхийг өөртөө шилжүүлэн авч борлуулах ажиллагааг эхэлнэ.

Зээлийн өрийн үлдэгдлийг барагдуулах зорилгоор ӨБҮХХ-ийг хүлээн авч өмчилсөн тохиолдолд тэнцлийн гадуурх Зээлийн барьцаа эд хөрөнгийн данснаас зарлагдаж, холбогдох зээлийн дүн болон уг хөрөнгийн зах зээлийн борлуулах үнэлгээний аль бага дүнгээр:

Дебет: ӨБҮХХ
Кредит: Холбогдох зээлийн данс

Хэрэв зээлийн дүн нь ӨБҮХХ-ийн борлуулах зах зээлийн үнэлгээнээс их байгаа тохиолдолд уг зөрүүг ЗЭС-аас эхэлж хаана.

ӨБҮХХ-ийг тэнцэлдээ бүртгэн авснаас хойш холбогдох журмын дагуу ӨБҮХХ-ийн эрсдэлийн санг зардлаар байгуулна.

Дебет: ӨБҮХХ-ийн эрсдэлийн зардал
Кредит: ӨБҮХХ-ийн эрсдэлийн сан

ӨБҮХХ-ийг борлуулах, ашиглах, хамгаалахтай холбогдон гарах зардлыг:

Дебет: Холбогдох зардлын данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

ӨБҮХХ-ийг тэнцэлд бүртгэсэн дүнгээс давуулан борлуулбал үндсэн дүнгээр:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: ӨБҮХХ
Кредит: Холбогдох орлогын данс

Хэрэв ББСБ нь ӨБҮХХ-ийг зээлийн үндсэн өр, хүү, торгууль болон зээлийг төлүүлэх, барьцаа хөрөнгийг борлуулахтай холбогдон гарсан зардлаас давсан дүнгээр борлуулсан боловч илүү гарсан дүнг зээлдэгчид буцаан олгох тухай гэрээнд заасан бол:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: ӨБҮХХ-ийн данс

Дебет: Өглөг
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

ӨБҮХХ нь тэнцэлд бүртгэсэн үнээс багаар борлогдсон тохиолдолд борлуулсан үнийн дүнгээр:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: ӨБҮХХ

Хэрэв анхны үнэлгээнээс дутуу үнээр борлуулбал:

Дебет: ӨБҮХХ-ийн эрсдэлийн сан
Кредит: ӨБҮХХ

ӨБҮХХ нь борлогдох боломжгүй болсон тохиолдолд ӨБҮХХ-ийн эрсдэлийн сангаар хаана.

1. Тодорхойлолт

Авлага гэж нийлүүлсэн бараа, ажил, үйлчилгээний үнэ, хүлээн аваагүй байгаа бусдаас авахаар хүлээн зөвшөөрөгдсөн тооцоо юм. ББСБ-ын хувьд энэ авлагад үндсэн бус үйл ажиллагаанаас үүссэн авлагыг хамруулна. Тухайлбал; зээлээр борлуулсан эд хогшил, ажиллагсад болон бусад байгууллага, хүмүүсээс авах зээлээс бусад тооцооны авлага гэх мэт.

Материал, үнэ бүхий зүйл гэж ББСБ-ын хувьд үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэгдэх материал буюу хангамжийн зүйлсийн хэлбэрээр байгаа хөрөнгө юм.

Урьдчилгаа гэж өмнө нь хөрөнгө оруулалтын бус зориулалтаар төлсөн мөнгө буюу бэлтгэн нийлүүлэгчид төлсөн урьдчилгаа болон урьдчилан төлсөн зардлууд.

2. Хамрагдах зүйлс:

Бусад хөрөнгөд дараах зүйлс орно. Үүнд:

- Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага
- Бусад авлага
- Материал, үнэ бүхий зүйлс
- Урьдчилгаа

3. Үнэлгээ

Авлага нь хүлээн авахаар урьдчилан тооцсон цэвэр боломжит хэмжээгээр үнэлэгдэнэ. Өөрөөр хэлбэл, түүний нэрлэсэн үнээс найдваргүй авлагад байгуулсан эрсдэлийн санг хасч тооцсон төлөгдөх боломжтой цэвэр дүнгээр илэрхийлнэ.

Бараа материалыг өртгөөр нь бүртгэнэ. Бараа материалын өртөг нь худалдан авахад гарсан зардал, одоогийн байдалд оруулахтай холбогдон гарсан шууд ба шууд бус зардлыг багтаасан байна. ББСБ-ын хувьд материал нь ихэнхдээ хангамжийн зүйл ба худалдан борлуулах зориулалтгүй тул үнэлгээний хасагдуулгыг авч үзэхгүй.

Урьдчилгааг түүний банк бус санхүүгийн байгууллагаас төлсөн үнэ буюу нэрлэсэн үнээр илэрхийлнэ.

4. Санхүүгийн тайланд тусгах нь:

Бусад хөрөнгийг балансын Хөрөнгө талд 7 дахь зүйл болгон тусгана.

5. Хяналт ба бүртгэл

Салбар хоорондын тооцоог төвийн, салбарын гэсэн хоёр түвшинд явуулах ба салбар хоорондын тооцооны нийлэлтэнд ББСБ-ын төвөөс нэгдсэн хяналт тавина.

Салбар хоорондын тооцоог тогтмол нийлэх ба Дотоод хяналтын алба нь салбар хоорондын тооцооны нийлэлтэнд хяналт тавьж байна. Бусад хөрөнгийн дансдын тэнцлийн үлдэгдлийг тогтмол нийлж тохируулна.

Бусад хөрөнгийн дансдын гүйлгээнд ерөнхий нягтлан бодогч, ББСБ-ын дотоод хяналтын алба тогтмол хяналт тавина.

7.1 Авлагын бүртгэл

Иргэд, хуулийн этгээд, ажиллагсдаас эд хөрөнгийн тооцоогоор авах зээлээс бусад төрлийн авлагыг хамруулна. Авлагад байгууллага, хүмүүсээс авах авлага, хуримтлуулж тооцсон хүүгийн авлага, салбар хоорондын авлага орно.

Касс үнэ бүхий зүйлтэй холбогдох бусдаас авах авлагыг бүртгэнэ.

Авлагын дансны үлдэгдэл нь түр хугацааны шинж чанартай бөгөөд эцсийн тооцоо хийгдсэн тухай бүр хаагдаж байх ёстой. Авлагыг иргэн, хуулийн этгээд тус бүрээр нэрийн данс нээж хөтөлнө.

ББСБ нь авлага барагдуулахад тогтмол хяналт тавьж ажиллах бөгөөд авлагын ангилал хийж найдваргүй авлагын нөөц байгуулж дараах дансны бичилтийг хийнэ.

Дебет: Найдваргүй авлагын зардал
Кредит: Найдваргүй авлагын нөөц

Авлагыг төлүүлж авч чадахгүй болсон тохиолдолд найдваргүй авлагын нөөцөөс авлагыг хаахдаа ББСБ-ын удирдлагын шийдвэрийг үндэслэнэ.

Дебет: Найдваргүй авлагын нөөц
Кредит: Авлагын холбогдох данс

7.2 Салбар хоорондын тооцооны бүртгэл

Салбар хоорондын тооцоо нь бэлэн ба бэлэн бус хэлбэрээр байж болно. Салбар хоорондын тооцоогоор үүссэн өглөг, авлагыг салбар нэгж бүр дээр нэрийн данс нээж бүртгэх бөгөөд өөр үлдэгдлийг бүртгэхийг хориглоно.

Салбар хоорондын тооцоо нь зөвхөн ББСБ-ын төвөөр дамжиж хийгдэнэ.

Салбар хоорондын тооцооны данс актив, пассив хоёр үлдэгдэлтэй байвал цэвэршүүлэн аль нэгээр нь санхүүгийн тайланд үзүүлнэ.

ББСБ өөрийн салбар нэгжид мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээ хийхэд:

ББСБ-ын төв нь:

Дебет: Салбар хоорондын тооцооны авлага
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Салбар нэгж нь:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кредит: Салбар хоорондын тооцооны өглөг

7.3 Урьдчилгаа тооцооны бүртгэл

7.3.1 Дараа тайлангийн тооцоо

Урьдчилж төлсөн тооцоо дансаар захиргааны ба аж ахуйн ажил үүрэг гүйцэтгэх буюу гадаад дотоодод албан томилолт, курс сургууль, семинарт явах зэрэгт зориулан удирдлагын шийдвэрийн дагуу урьдчилгаа мөнгө олгосон тохиолдолд:

Дебет: Дараа тайлангийн тооцооны данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Урьдчилгаанд олгосон мөнгөний зарцуулалтын тооцооны баримтыг үндэслэн дараа тайлангийн тооцооны дансыг хаахдаа:

Дебет: Холбогдох зардлын данс
Кредит: Дараа тайлангийн тооцооны данс

Дараа тайлангийн тооцоо дансны хувьд тооцоо үүссэн ажилтан бүрээр нэрийн данс нээн, дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж, тухайн ажилтны хувьд үүссэн тооцоо, баримтыг тулгаж, үлдэгдлийг сар бүрээр тохируулна.

Урьдчилгаанд олгосон мөнгөнөөс илүү, дутуу зарцуулсан бол зөрүүг нэмж олгох буюу буцааж тушаалгана.

7.3.2 Урьдчилж төлсөн тооцоо

Бараа, үйлчилгээг хүлээн аваагүй үед төлбөрийг урьдчилж гүйцэтгэхэд

Дебет: Урьдчилж төлсөн тооцоо
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох дансд

Бараа, үйлчилгээг хүлээж авсан үед

Дебет: Холбогдох хөрөнгийн данс эсвэл зардал
Кредит: Урьдчилж төлсөн тооцоо

7.3.3 Урьдчилж төлсөн зардал

Хууль тогтоомжийн дагуу төлөх татвар, шимтгэл болон байгууллага, хүмүүстэй хийсэн гэрээгээр үйл ажиллагааны зардлыг урьдчилан төлбөл Урьдчилж төлсөн зардал дансаар

хуримтлуулан бүртгэж байгаад тайлант үед ногдох хэмжээгээр холбогдох зардлын дансад хуваарилж бүртгэнэ.

Дебет: Урьдчилж төлсөн зардал
Кредит: Мөнгөн хөрөнгийн дансд

Урьдчилж төлсөн зардлыг холбогдох тайлант үед хуваарилах буюу зардал бодит болсон үед:

Дебет: Холбогдох зардлын дансд
Кредит: Урьдчилж төлсөн зардал

7.4 Материал, үнэ бүхий зүйлсийн бүртгэл

ББСБ-ын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах материал үнэ бүхий зүйл, бүх төрлийн маягтуудыг Материалын дансанд бүртгэнэ.

Материал үнэ бүхий зүйл, маягтыг ББСБ-ын үйл ажиллагааг явуулах хэмжээгээр бэлтгэн, нярав /эд хариуцагч/ агуулахын бүртгэлийг давхар хөтлөх ба зааврын дагуу тооллогын ажлын хэсэг нь ээлжит тооллогыг бүтэн жилээр, ээлжит бус тооллогыг нярав болон эд хариуцагч ажлаас өөрчлөгдөх болон бусад шалтгаанаар тухай бүр явуулна.

Материал үнэ бүхий зүйл, маягтуудыг ББСБ худалдан авахдаа холбогдох зарлагын баримтыг үндэслэн үнэ бүхий зүйл хариуцсан няравын /эд хариуцагч/ материалын орлогын баримтыг үндэслэн:

Дебет: Материал
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Материал үнэ бүхий зүйл, маягтуудыг зарлага болгохдоо эрх бүхий хүмүүсийн зөвшөөрсөн баримтыг үндэслэн бичсэн зарлагын баримтаар:

Дебет: Холбогдох зарлагын данс /бичиг хэрэг, ариун цэврийн гэх мэт/
Кредит: Материалын данс гэсэн бичилт хийж нярав эд хариуцагч нь орлого зарлагын баримтыг үндэслэн тухай бүр материалын бүртгэлийг хөтөлнө.

Б-8 САНХҮҮГИЙН ҮҮСМЭЛ ХЭРЭГСЭЛ /САНХҮҮГИЙН ДЕРИВАТИВ/

1. Тодорхойлолт

Санхүүгийн дериватив гээж өртөг нь ямар нэг суурь хүчин зүйлс (*тухайлбал, зах зээлийн үнэ, хүү, ханш, индекс, зээлдэгчийн төлбөрийн чадвар г.м*)-ийн нөлөөн доор өөрчлөгдөж, ирээдүйд буюу тодорхой хугацааны дараа хэрэгждэг санхүүгийн хэрэгслийг хэлнэ.

Үүнд санхүүгийн деривативын анхны өртөг нь суурь хүчин зүйлсийн өөрчлөлтөд ижил нөлөөтэй бусад санхүүгийн хэрэгслийг худалдан авахад шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээнээс ямагт бага байна.

2. Шинж чанар

- Хүү, үнэ, гадаад валютын ханш, үнийн болон хүүгийн индекс, зээлдэгчийн зэрэглэл, зээлийн индекс болон бусад хүчин зүйлсээс хамааран өртөг нь өөрчлөгдөх,

- Зах зээлийн хүчин зүйлийн өөрчлөлт нь ижил төстэйгээр нөлөөлдөг санхүүгийн хэрэгсэлтэй харьцуулахад анхны цэвэр хөрөнгө оруулалт шаардахгүй, аль эсвэл харьцангуй бага хэмжээний анхны цэвэр хөрөнгө оруулалт шаардах,
- Ирээдүйд хэрэгжих зэрэг шинж чанарыг агуулна.

3. Санхүүгийн тайланд тусгах нь

Санхүүгийн деривативыг гэрээ, хэлцэл байгуулсан өдрөөс эхлэн санхүүгийн тайланд тусгана. Өөрөөр хэлбэл санхүүгийн деривативыг санхүүгийн тайланд тусгахдаа хэрэгжих хугацааг нь харгалзахгүй байж болно.

4. Хяналт ба бүртгэл

Санхүүгийн деривативын дансдын байршил, үлдэгдлийн хэмжээ, төлөгдөх хугацааны зөрүүг зохистой хэмжээнд байлгана.

Санхүүгийн деривативыг тэнцлийн Хөрөнгө талд 8 дахь зүйл болгон ангилна.

Санхүүгийн деривативын тэнцлийн дансдын туслах журнал хөтөлнө. Гүйлгээний баримтанд байгууллагын холбогдох ажилтан, албан тушаалтнууд нэг, хоёрдугаар гарын үсэг зурж баталгаажуулна.

Гүйлгээг үндсэн баримттай нь тулган шалгаж сард нэгээс доошгүй удаа нийлж тохируулна.

Б-8.1 САНХҮҮГИЙН ҮҮСМЭЛ ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ

8.1 Форвард (Forward) ба фьючерсийн (futures) гэрээ хэлцэл

Форвард ба фьючерсийн гэрээ хэлцэл гэж зах зээлийн индекс, хүү, гадаад валют болон санхүүгийн бусад хэрэгслийг тодорхой хугацааны дараа, тодорхой үнэ, ханшаар арилжаалах гэрээ, хэлцлийг хэлнэ. Үүнд: тодорхой хугацаа гэдэгт спот хоногоос илүү урт хугацааг ойлгоно. Спот хэлцэл гадаад валютын арилжааг ажлын хоёр өдөрт багтаан гүйцэтгэх хэлцэл.

Форвард болон фьючерсийн гэрээ хэлцэлтэй холбоотойгоор үүсэх өглөг, авлагыг тайлант үеийн зах зээлийн үнэ, ханшаар нь тэнцэлд тусгана. Өглөг авлагад бүртгэсэн хөрөнгийг тухайн арилжааны позици хаах хүртэл буюу хэлцлийн хугацаа дуусах хүртэл бүртгэж, өглөг авлагын дансдыг хаахад үүсэх дүнгээр арилжааны орлого, зарлагад бүртгэнэ.

Форвард болон фьючерсийн гэрээ хэлцэлтэй холбоотой бүртгэлийг гадаад валютын арилжаатай холбоотой жишээн дээр авч үзье.

1. Гадаад валютыг форвард, фьючерс арилжаагаар худалдан авах арилжааг бүртгэхэд:

Дебет: Форвард, фьючерс арилжааны авлагын түр данс /худалдан авах валютын дүнгээр/

Кредит: Валют хөрвүүлэх түр данс

Дебет: Валют хөрвүүлэх түр данс

Кредит: Форвард, фьючерс арилжааны өглөгийн түр данс /худалдах валютын дүнгээр/

Дээрх гүйлгээний үр дүнд Валют хөрвүүлэх түр дансны үлдэгдэл эерэг бол:

Дебет: Валют хөрвүүлэх түр данс

Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Сөрөг бол:

Дебет: Гадаад валютын арилжааны зарлага

Кредит: Валют хөрвүүлэх түр данс

Монголбанкнаас зарласан ханш өөрчлөгдөх тухай бүрд хэлцлийн үнийг сар бүр дахин үнэлэн зөрүү дүнгээр нь гадаад валютын арилжааны орлого, зарлагад бүртгэнэ. /Гэхдээ уг дахин үнэлгээг хэлцлийн валютад биш, зөвхөн түүнийг илэрхийлэх валютын дүнд өөрчлөлт хийх замаар үнэлнэ. Өөрөөр хэлбэл, хэлцлийн валют анх бүртгэгдсэн дүнгээс өөрчлөгдөхгүй, түүнийг илэрхийлэх валютын дүн зах зээлийн ханшаар зохицуулагдана/.

Хэрэв Монголбанкнаас зарласан ханшаас өндөр байвал:

Дебет: Гадаад валютын форвард, фьючерс арилжааны зарлага

Кредит: Форвард, фьючерс арилжааны өглөгийн түр данс

Хэрэв зах зээлийн ханш хэлцлийн ханшаас доогуур бол:

Дебет: Форвард, фьючерс арилжааны өглөгийн түр данс

Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Форвард, фьючерс хэлцлийн хугацаа дуусахад худалдан авах валютын дүнгээр:

Дебет: Мөнгөн хөрөнгийн гадаад валютын холбогдох данс

Кредит: Форвард, фьючерс арилжааны авлагын түр данс

Хэлцлээр худалдах валютын дүнгээр:

Дебет: Форвард, фьючерс арилжааны өглөгийн түр данс

Кредит: Мөнгөн хөрөнгийн гадаад валютын холбогдох данс

Дээрх гүйлгээ хийгдсэний дараа худалдан авах гадаад валютын форвард арилжааны авлагын түр данс бүрэн хаагдаж өглөгийн дансны үлдэгдлээр тухайн арилжааны үр дүнг тооцно.

Ашигтай бол:

Дебет: Форвард, фьючерс арилжааны өглөгийн түр данс

Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Алдагдалтай бол:

Дебет: Гадаад валютын арилжааны зарлага
Кредит: Форвард, фьючерс арилжааны өглөгийн түр данс.

Гадаад валютыг форвард, фьючерс арилжаагаар худалдах арилжааг бүртгэхэд:

Дебет: Форвард, фьючерс арилжааны авлагын түр данс /худалдан авах валютын дүнгээр/
Кредит: Валют хөрвүүлэх түр данс

Дебет: Валют хөрвүүлэх түр данс
Кредит: Форвард, фьючерс арилжааны өглөгийн түр данс /худалдах валютын дүнгээр/

Дээрх гүйлгээний үр дүнд Валют хөрвүүлэх түр дансны үлдэгдэл эерэг бол:

Дебет: Валют хөрвүүлэх түр данс
Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Сөрөг бол:

Дебет: Гадаад валютын арилжааны зарлага
Кредит: Валют хөрвүүлэх түр данс.

Монголбанкнаас зарласан ханш өөрчлөгдөх тухай бүрт хэлцлийн үнийг сар бүр дахин үнэлэн зөрүү дүнгээр нь гадаад валютын арилжааны орлого, зарлагад бүртгэнэ. /Дээрхийн нэгэн адил уг дахин үнэлгээг хэлцлийн валютад биш, зөвхөн түүнийг илэрхийлэх валютын дүнд өөрчлөлт хийх замаар үнэлнэ/.

Хэрэв зах зээлийн ханш хэлцлийн ханшаас өндөр байвал:

Дебет: Гадаад валютын арилжааны зардал
Кредит: Форвард, фьючерс арилжааны авлагын түр данс

Хэрэв зах зээлийн ханш хэлцлийн ханшаас доогуур бол:

Дебет: Форвард, фьючерс арилжааны авлагын түр данс
Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Форвард хэлцлийн хугацаа дуусахад худалдах валютын дүнгээр:

Дебет: Форвард, фьючерс арилжааны өглөгийн түр данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн гадаад валютын холбогдох данс

Худалдан авах валютын дүнгээр:

Дебет: Мөнгөн хөрөнгийн гадаад валютын холбогдох данс
Кредит: Форвард, фьючерс арилжааны авлагын түр данс

Дээрх гүйлгээ хийгдсэний дараа худалдах валютын дүнгээр гадаад валютын форвард арилжааны өглөгийн данс бүрэн хаагдаж, авлагын дансны үлдэгдлээр тухайн арилжааны үр дүнг тооцно.

Ашигтай бол:

Дебет: Форвард, фьючерс арилжааны авлагын түр данс
Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Алдагдалтай бол:

Дебет: Гадаад валютын арилжааны зарлага
Кредит: Форвард, фьючерс арилжааны авлагын түр данс.

8.2 Своп /Swap/ гэрээ хэлцэл

Своп үүсмэл санхүүгийн хэрэгсэл гэж хоёр бие даасан арилжаа (төлбөр тооцоо)-г тодорхой хугацааны дараа хийж гүйцэтгэхээр байгуулсан гэрээ хэлцлийг хэлнэ. Тухайлбал, гадаад валютын хувьд спот арилжааг форвард арилжаатай, аль эсвэл хоёр форвард арилжааг хослуулан хэрэглэсэн бол своп хэлбэрийн гэрээ, хэлцэл байгуулсанд тооцно.

Своп гэрээ, хэлцлийг байгуулснаар ББСБ ирээдүйд тодорхой хэмжээний үүрэг хүлээж байгаа гэдэг үүднээс ирээдүйд үүсэх өглөг, авлагын хэлцэл хийсэн тухай бүрт хэлцлийн ханшаар анх тэнцэлд бүртгэнэ. Гадаад валютын арилжааны хувьд хэлцлийн үнийг тухайн позици хаах буюу хэлцлийн хугацаа дуусах өдөр хүртэл Монголбанкнаас зарласан ханшаар дахин үнэлэн бүртгэж, өглөг авлагын дансдыг хаахад үүсэх зөрүү дүнгээр своп арилжааны орлого, зарлагад бүртгэнэ.

Санхүүгийн тайланд своп арилжаагаар үүссэн өглөг, авлагын дансдыг цэвэршүүлж харуулна. Своп арилжаатай холбоотой бүртгэлийг гадаад валютын арилжаан дээр жишээ болгон харуулья.

1. Своп хэлцэл. Худалдах/худалдан авах нөхцөлтэй/

а) Своп хэлцлийн дагуу гадаад валютыг худалдах гүйлгээ хийхэд үндсэн баримтуудыг бүрдүүлж, дараах гүйлгээг хийнэ.

Дебет: Своп арилжааны авлагын данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн гадаад валютын холбогдох данс /өнөөдөр худалдах буюу ирээдүйд худалдан авах гадаад валютын дүн /

Дебет: Мөнгөн хөрөнгийн гадаад валютын холбогдох данс
Кредит: Своп арилжааны өглөгийн данс /өнөөдөр худалдан авах буюу ирээдүйд худалдах гадаад валютын дүн /

Монголбанкнаас зарласан ханш өөрчлөгдөх тухай бүрт хэлцлийн үнийг сар бүр дахин үнэлэн зөрүү дүнгээр нь гадаад валютын арилжааны орлого, зарлагад бүртгэнэ. /Гэхдээ уг дахин үнэлгээг хэлцлийн валютад биш, зөвхөн түүнийг илэрхийлэх валютын дүнд өөрчлөлт хийх замаар үнэлнэ. Өөрөөр хэлбэл, хэлцлийн валют анх бүртгэгдсэн дүнгээс өөрчлөгдөхгүй, түүнийг илэрхийлэх валютын дүн зах зээлийн ханшаар зохицуулагдана/.

Хэрэв зах зээлийн үнэ хэлцлийн үнээс өндөр байвал:

Дебет: Гадаад валютын арилжааны зарлага
Кредит: Своп арилжааны өглөгийн түр данс

Хэрэв зах зээлийн үнэ хэлцлийн үнээс бага байвал:

Дебет: Своп арилжааны өглөгийн түр данс
Кредит: Гадаад валютын арилжааны орлого гэж зах зээлийн үнээр үнэлнэ.

б) Хэлцлийн хугацаа дуусч гадаад валютыг эргүүлж худалдан авахад

Своп хэлцлийн гэрээгээр худалдан авах гадаад валютын дүнгээр:

Дебет: Мөнгөн хөрөнгийн гадаад валютын холбогдох данс
Кредит: Своп арилжааны авлагын түр данс

Своп хэлцлийн гэрээгээр худалдах гадаад валютын дүнгээр:

Дебет: Своп арилжааны өглөгийн түр данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн гадаад валютын холбогдох данс

Дээрх гүйлгээ хийгдсэний дараа гадаад валютын своп арилжааны авлагын данс хаагдаж, өглөгийн дансны үлдэгдлээр тухайн арилжааны үр дүнг тооцно.

Ашигтай бол:

Дебет: Своп арилжааны өглөгийн түр данс
Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Алдагдалтай бол:

Дебет: Гадаад валютын арилжааны зарлага
Кредит: Своп арилжааны өглөгийн түр данс гэж гүйлгээ хийснээр своп арилжааны позици хаагдана.

2. Своп хэлцэл. Худалдан авах/худалдах нөхцөлтэй/

а) Гэрээний нөхцлийн дагуу гадаад валютыг худалдан авахад:

Дебет: Мөнгөн хөрөнгийн гадаад валютын холбогдох данс

Кредит: Своп арилжааны өглөгийн түр данс /өнөөдөр худалдан авах буюу ирээдүйд худалдах гадаад валютын дүн /

Дебет: Своп арилжааны авлагын түр данс

Кредит: Мөнгөн хөрөнгийн гадаад валютын холбогдох данс /өнөөдөр худалдах буюу ирээдүйд худалдан авах гадаад валютын дүн /

Монголбанкнаас зарласан ханш өөрчлөгдөх тухай бүрт хэлцлийн үнийг сар бүр дахин үнэлэн зөрүү дүнгээр нь гадаад валютын арилжааны орлого, зарлагад бүртгэнэ. /Гэхдээ уг дахин үнэлгээг хэлцлийн валютад биш, зөвхөн түүнийг илэрхийлэх валютын дүнд өөрчлөлт хийх замаар үнэлнэ. Өөрөөр хэлбэл, хэлцлийн валют анх бүртгэгдсэн дүнгээс өөрчлөгдөхгүй, түүнийг илэрхийлэх валютын дүн зах зээлийн ханшаар зохицуулагдана./

Хэрэв зах зээлийн үнэ хэлцлийн үнээс өндөр байвал:

Дебет: Своп арилжааны авлагын түр данс
Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Хэрэв зах зээлийн үнэ хэлцлийн үнээс бага байвал:

Дебет: Гадаад валютын арилжааны зарлага
Кредит: Своп арилжааны авлагын түр данс гэж зах зээлийн үнээр үнэлнэ.

б) Гэрээний дагуу гадаад валютыг буцаан худалдахад

Своп хэлцлийн гэрээгээр худалдах гадаад валютын дүнгээр:

Дебет: Своп арилжааны өглөгийн түр данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн гадаад валютын холбогдох данс

Худалдан авах валютын дүнгээр:

Дебет: Мөнгөн хөрөнгийн гадаад валютын холбогдох данс
Кредит: Своп арилжааны авлагын түр данс

Дээрх гүйлгээ хийгдсэний дараа гадаад валютын своп арилжааны өглөгийн түр данс хаагдаж, своп арилжааны авлагын түр дансны үлдэгдлээр тухайн арилжааны үр дүнг тооцно.

Ашигтай бол

Дебет: Своп арилжааны авлагын түр данс
Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Алдагдалтай бол

Дебет: Гадаад валютын арилжааны зарлага
Кредит: Своп арилжааны авлагын түр данс гэж гүйлгээ хийгдсэнээр тухайн арилжааны позици хаагдана.

8.3 Опшин (Option) гэрээ хэлцэл

Опшин санхүүгийн үүсмэл хэрэгсэл гэж санхүүгийн хэрэгслийг тодорхой хугацааны дараа, урьдчилж тохирсон үнээр арилжаалах эрхийг хэлнэ.

Тайланд опшин арилжааны хэлцлээр үүссэн өглөг, авлагын дансдыг цэвэршүүлж харуулна. Опшины бүртгэлийг гадаад валютын арилжаан дээр жишээ болгон харуулья.

1. Гадаад валютын опшин арилжааны эрхийг худалдсан бол,

Гадаад валютын колл болон пут опшин хэлцлийн эрхийг худалдсан тохиолдолд үндсэн баримтуудыг бүрдүүлж дараах гүйлгээг хийнэ.

Опшин хэлцлийн эрхийг худалдсан үнийг /премиум/ орлогодож авахад

Дебет: Мөнгөн хөрөнгийн гадаад валютын холбогдох данс
Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Опшин арилжааны хэлцлээр ирээдүйд хүлээж болзошгүй үүрэг үүсч байгаа тул спот өдрөөр тэнцлийн опшин арилжааны түр дансад хэлцэлд дурдсан гадаад валютын дүнгээр өглөг, авлага үүсгэж, позици хаах буюу хэлцэл биелэгдэх өдөр хүртэл бүртгэнэ. Тэнцэлд анхны хэлцлийн үнээр тооцож бүртгэнэ.

Дебет: Опшин арилжааны авлагын түр данс
(Ирээдүйд худалдан авах валютын дүнгээр)
Кредит: Валют хөрвүүлэх түр данс

Дебет: Валют хөрвүүлэх түр данс
Кредит: Опшин арилжааны өглөгийн түр данс
(Ирээдүйд худалдах валютын дүнгээр)

Монголбанкнаас зарласан ханш өөрчлөгдөх тухай бүрт хэлцлийн үнийг сар бүр дахин үнэлэн зөрүү дүнгээр нь гадаад валютын арилжааны орлого, зарлагад бүртгэнэ. /Дахин үнэлгээг хэлцлийн валютад биш, зөвхөн түүнийг илэрхийлэх валютын дүнд өөрчлөлт хийх замаар үнэлнэ. Өөрөөр хэлбэл, хэлцлийн валют анх бүртгэгдсэн дүнгээс өөрчлөгдөхгүй, түүнийг илэрхийлэх валютын дүн зах зээлийн ханшаар зохицуулагдана./

Колл опшин арилжааны хувьд:

Хэрэв зах зээлийн үнэ тэнцлийн үнээс өндөр бол:

Дебет: Опшин арилжааны авлагын түр данс
Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Хэрэв зах зээлийн үнэ тэнцлийн үнээс бага бол:

Дебет: Гадаад валютын арилжааны зарлага
Кредит: Опшин арилжааны авлагын түр данс

Пут опшин арилжааны хувьд:

Хэрэв зах зээлийн үнэ тэнцлийн үнээс өндөр бол:

Дебет: Гадаад валютын арилжааны зарлага
Кредит: Опшин арилжааны өглөгийн түр данс

Хэрэв зах зээлийн үнэ тэнцлийн үнээс бага бол:

Дебет: Опшин арилжааны өглөгийн түр данс
Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Хэлцлийн хугацаа дуусахад

а) Хэлцэл биелсэн бол хэлцлийн гэрээгээр худалдан авах гадаад валютын дүнгээр:

Дебет: Мөнгөн хөрөнгийн гадаад валютын холбогдох данс
Кредит: Опшин арилжааны авлагын түр данс /худалдах гадаад валютын дүнгээр/

Дебет: Опшин арилжааны өглөгийн түр данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн гадаад валютын холбогдох данс

б) Хэлцэл биелээгүй бол:

Дебет: Опшин арилжааны өглөгийн түр данс
Кредит: Гадаад Валют хөрвүүлэх түр данс

Дебет: Гадаад Валют хөрвүүлэх түр данс
Кредит: Опшин арилжааны авлагын түр данс

Дээрх хоёр гүйлгээ (а,б) хийгдсэний дараа гадаад валютын опшин арилжааны авлага, өглөгийн түр дансд хаагдсанаар опшин арилжааны позици хаагдаж, тухайн арилжааны төрөл болон хэлцэл биелсэн ба үл биелсэнээс хамаарч валют хөрвүүлэх түр данс, опшин арилжааны авлага, өглөгийн түр дансдын аль нэг нь үлдэгдэлтэй үлдэхэд энэ үлдэгдлээр тухайн арилжааны үр дүнг тооцож гадаад валютын арилжааны орлого, зарлагад бүртгэнэ.

Ашигтай бол:

Дебет: Валют хөрвүүлэх түр данс эсвэл
Опшин арилжааны өглөгийн түр данс
Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Алдагдалтай бол:

Дебет: Гадаад валютын арилжааны зарлага
Кредит: Валют хөрвүүлэх түр данс эсвэл
Опшин арилжааны авлагын түр данс гэж гүйлгээ хийнэ.

2. Гадаад валютын опшин арилжааны эрхийг худалдан авах

Гадаад валютын колл болон пут опшин хэлцлийн эрхийг худалдан авсан бол үндсэн баримтуудыг бүрдүүлж дараах гүйлгээг хийнэ.

Опшин хэлцлийн эрхийг худалдан авах үнийг /премиум/ төлөхөд:

Дебет: Гадаад валютын арилжааны зарлага

Кредит: Мөнгөн хөрөнгийн гадаад валютын холбогдох данс

Опшин арилжааны хэлцлээр ирээдүйд хүлээж болзошгүй үүрэг үүсч байгаа тул тэнцлийн опшин арилжааны түр дансдад хэлцэлд дурдсан гадаад валютын дүнгээр өглөг, авлага үүсгэж бүртгэнэ.

Дебет: Опшин арилжааны авлагын түр данс

(Ирээдүйд худалдан авах гадаад валютын дүнгээр)

Кредит: Валют хөрвүүлэх түр данс

Дебет: Валют хөрвүүлэх түр данс

Кредит: Опшин арилжааны өглөгийн түр данс

(Ирээдүйд худалдах гадаад валютын дүнгээр)

Дээрх гүйлгээ хийгдсэний дараа гадаад Валют хөрвүүлэх түр дансны үлдэгдлээр тухайн арилжааны орлого, зарлагад бүртгэнэ.

Монголбанкнаас зарласан ханш өөрчлөгдөх тухай бүрт хэлцлийн үнийг сар бүр дахин үнэлэн зөрүү дүнгээр нь гадаад валютын арилжааны орлого, зарлагад бүртгэнэ.

Колл опшин арилжааны хувьд:

Хэрэв зах зээлийн үнэ тэнцлийн үнээс өндөр бол:

Дебет: Гадаад валютын арилжааны зарлага

Кредит: Опшин арилжааны өглөгийн түр данс

Хэрэв зах зээлийн үнэ тэнцлийн үнээс бага бол:

Дебет: Опшин арилжааны өглөгийн түр данс

Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Пут опшин арилжааны хувьд:

Хэрэв зах зээлийн үнэ тэнцлийн үнээс давсан бол:

Дебет: Опшин арилжааны авлагын түр данс

Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Хэрэв зах зээлийн үнэ тэнцлийн үнээс бага бол:

Дебет: Гадаад валютын арилжааны зарлага

Кредит: Опшин арилжааны авлагын түр данс

Хэлцлийн хугацаа дуусахад

а) Хэлцэл биелсэн бол гэрээгээр худалдан авах гадаад валютын дүнгээр:

Дебет: Мөнгөн хөрөнгийн гадаад валютын холбогдох данс

Кредит: Опшин арилжааны авлагын түр данс

Худалдах валютын дүнгээр:

Дебет: Опшин арилжааны өглөгийн түр данс

Кредит: Мөнгөн хөрөнгийн гадаад валютын холбогдох данс

б) Хэлцэл биелээгүй бол:

Дебет: Опшин арилжааны өглөгийн түр данс

Кредит: Гадаад Валют хөрвүүлэх түр данс

Дебет: Гадаад Валют хөрвүүлэх түр данс

Кредит: Опшин арилжааны авлагын түр данс

Дээрх хоёр гүйлгээ (а,б) хийгдсэний дараа гадаад валютын опшин арилжааны авлага, өглөгийн түр дансд хаагдсанаар опшин арилжааны позици хаагдаж, тухайн арилжааны төрөл болон хэлцэл биелсэн ба үл биелснээс хамаарч валют хөрвүүлэх түр данс, опшин арилжааны авлага, өглөгийн түр дансдын аль нэг нь үлдэгдэлтэй байна. Энэ үлдэгдлээр тухайн арилжааны үр дүнг тооцож Гадаад валютын арилжааны орлого, зарлагад бүртгэнэ.

Ашигтай бол:

Дебет: Гадаад Валют хөрвүүлэх түр данс

эсвэл Опшин арилжааны өглөгийн түр данс

Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Алдагдалтай бол:

Дебет: Гадаад валютын арилжааны зарлага

Кредит: Гадаад Валют хөрвүүлэх түр данс

эсвэл Опшин арилжааны авлагын түр данс гэж гүйлгээ хийнэ.

8.4 Спот / Spot/ арилжаа

Спот хэлцэл -гадаад валютын арилжааг ажлын хоёр өдөрт багтаан гүйцэтгэх хэлцэл. Спот хэлцлээр хийгдэх арилжааг дараах байдлаар бүртгэнэ.

а) Гадаад валютыг худалдан авах, худалдах арилжаа нь төгрөгийн эсрэг байвал дараах бичилтийн дагуу гүйлгээг хийнэ.

Бэлэн ба бэлэн бусаар гадаад валют худалдан авахад:

Дебет: Мөнгөн хөрөнгийн гадаад валютын холбогдох данс

Кредит: Мөнгөн хөрөнгийн төгрөгийн холбогдох данс

Бэлэн ба бэлэн бусаар гадаад валют худалдахад дараах гүйлгээг хийнэ. Үүнд:

Худалдах ханшаар:

Дебет: Мөнгөн хөрөнгийн төгрөгийн холбогдох данс
Кредит: Гадаад валютын арилжааны эх үүсвэр
Монголбанкнаас зарласан ханшаар:

Дебет: Гадаад валютын арилжааны эх үүсвэр
Кредит: Мөнгөн хөрөнгийн гадаад валютын холбогдох данс

Ашигтай бол:

Дебет: Гадаад валютын арилжааны эх үүсвэр
Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Алдагдалтай бол:

Дебет: Гадаад валютын арилжааны алдагдал
Кредит: Гадаад валютын арилжааны эх үүсвэр

б) Гадаад валютыг худалдан авах, худалдах арилжаа нь төгрөгөөс бусад гадаад валютын эсрэг байвал дараах бичилтийн дагуу гүйлгээг хийнэ.

Бэлэн ба бэлэн бусаар худалдан авахад гадаад валютын дүнгээр:

Дебет: Мөнгөн хөрөнгийн гадаад валютын холбогдох данс
Кредит: Валют хөрвүүлэх түр данс

Худалдах гадаад валютын дүнгээр:

Дебет: Валют хөрвүүлэх түр данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн гадаад валютын холбогдох данс

Ашигтай бол:

Дебет: Валют хөрвүүлэх түр данс
Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Алдагдалтай бол:

Дебет: Гадаад валютын арилжааны алдагдал
Кредит: Валют хөрвүүлэх түр данс

Дээрх гүйлгээ хийгдсэний дараа Валют хөрвүүлэх түр данс үлдэгдэлгүй болно. Тэнцэлд валют хөрвүүлэх дансыг үлдэгдэлтэй байлгахыг хориглоно.

Б-8А ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖАА

1. Тодорхойлолт

Ашиг олох зорилгоор гадаад валютыг худалдах, худалдан авах үйл ажиллагааг хамаарна.

2. Санхүүгийн тайланд тусгах нь:

Гадаад валютыг нэр төрөл тус бүрээр нэрийн данс нээж төгрөг, валютаар давхар бүртгэнэ. Гадаад валютын үлдэгдлийг Монголбанкнаас зарласан ханшаар тухай бүр тэгшитгэн тайлант хугацааны цэвэр орлого, зарлагад оруулна.

3. Хяналт ба бүртгэл

Гадаад валютын дансдын байршил, үлдэгдлийн хэмжээ, төлөгдөх хугацааны зөрүүг зохистой хэмжээнд байлгана. Гадаад валютыг худалдан авах, худалдахад хязгаар тогтооно.

Гадаад валютын тэнцлийн дансдын туслах журнал хөтөлнө. Гүйлгээг үндсэн баримттай тулган шалгаж сард нэгээс доошгүй удаа нийлж тохируулна.

Б-8А. ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ БҮРТГЭЛ

8А.1 Бэлэн гадаад валютын арилжаа

Бэлнээр гадаад валют худалдан авахад:

Дебет: Бэлэн гадаад валют
Кредит: Касс дахь бэлэн мөнгө

Бэлнээр гадаад валют худалдахад:

Дебет: Касс дахь бэлэн мөнгө
Кредит: Бэлэн гадаад валют /Худалдах ханшаар/

Дебет: Касс дахь бэлэн мөнгө
Кредит: Гадаад валютын арилжааны төгрөгийн эх үүсвэр

Монголбанкнаас зарласан ханшаар

Дебет: Гадаад валютын арилжааны төгрөгийн эх үүсвэр
Кредит: Бэлэн гадаад валют

Гадаад валют худалдсаны зөрүү ашгийн дүнгээр

Дебет: Гадаад валютын арилжааны төгрөгийн эх үүсвэр

Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Гадаад валют худалдсаны зөрүү алдагдлын дүнгээр

Дебет: Гадаад валютын арилжааны зардал
Кредит: Гадаад валютын арилжааны төгрөгийн эх үүсвэр

8А.2 Гадаад валютын ханшийн тэгшитгэл

ББСБ нь төгрөгийн ханшийн өөрчлөлтийг актив, пассивын дансанд Монголбанкнаас ханш зарласан тухай бүр ханшийн тэгшитгэл хийж байх бөгөөд төгрөгийн ханшийн бууралтаас тэнцлийн гадаад актив дансны хуучин, шинэ үнэлгээний зөрүүгээр:

Дебет: Гадаад валютаар илэрхийлэгдэх бүх актив данс

Кредит: Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого

Гадаад пассив дансны хуучин, шинэ үнэлгээний зөрүүгээр:

Дебет: Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал

Кредит: Гадаад валютаар илэрхийлэгдэх бүх пассив данс

Төгрөгийн ханш өссөн нөхцөлд гадаад актив дансны хуучин, шинэ үнэлгээний зөрүүгээр:

Дебет: Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал

Кредит: Гадаад валютаар илэрхийлэгдсэн бүх актив данс

Гадаад пассив дансны хуучин, шинэ үнэлгээний зөрүүгээр:

Дебет: Гадаад валютаар илэрхийлэгдсэн бүх пассив данс

Кредит: Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого

Тайлбар:

Төгрөгийн ханшийн бууралтын үед гадаад актив нь пассиваасаа давсан тохиолдолд ханшийн тэгшитгэлийн орлого, зардлын цэвэр зөрүү нь Орлого, гадаад пассив нь активаасаа давсан тохиолдолд Зарлага болно.

Төгрөгийн ханшийн өсөлтийн үед гадаад актив нь пассиваасаа давсан тохиолдолд ханшийн тэгшитгэлийн орлого, зарлагын зөрүү нь Зарлага, гадаад пассив нь активаасаа давсан тохиолдолд Орлого болно.

Б-9.1 ҮНДСЭН БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ

1. Тодорхойлолт

Нэг жилээс дээш хугацаанд ашиглагдах, ашиглалтын боломжит хугацаа нь хязгаарагдмал бизнесийн хэвийн нөхцөлд худалдах зориулалтгүй, үйлчилгээний болон захиргааны зориулалтаар ашиглагдах элэгдлийн үндсэн дээр өртөг, зардалд анхны үнээ аажмаар шингээж байдаг биет хөрөнгүүд байна.

Үндсэн хөрөнгөд газар, барилга байгууламж, эд хогшил, техник хэрэгсэл, дуусаагүй барилга багтана.

2. Үнэлгээ

Үндсэн хөрөнгийг анхны өртөгөөр нь бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн анхны өртөгт худалдан авсан үнэ, түүнийг бэлтгэхтэй холбогдон гарсан аливаа зардлыг (тээврийн зардал,

гаалийн татвар, хураамж, угсарч суурилуулах, ачиж буулгах зардал гэх мэт) оруулна. Хандиваар авсан хөрөнгийг зах зээлийн үнээр бүртгэнэ.

Үндсэн хөрөнгө нь анхны өртөгөөс хуримтлагдсан элэгдлийг хасч тооцсон үлдэгдэл өртөгөөр илэрхийлэгдэнэ.

Тэнцлийн үнэлгээ зах зээлийн үнэлгээнээс зөрөх тохиолдолд байгууллага, ТУЗ-ийн шийдвэрийн дагуу үндсэн хөрөнгөнд дахин үнэлгээ хийж, энэ талаар санхүүгийн тайланд тайлбар хийнэ.

3. Санхүүгийн тайланд тусгах нь:

Үндсэн хөрөнгийг балансын Хөрөнгө талд 9 дахь зүйл болгон бүртгэнэ. Үндсэн хөрөнгийг нэр төрлөөр тусад нь ангилан тайланд үзүүлнэ.

4. Хяналт ба бүртгэл

Гүйлгээний баримтанд байгууллагын холбогдох ажилтан, албан тушаалтнууд нэг, хоёрдугаар гарын үсэг зурж баталгаажуулна.

Үндсэн хөрөнгөнд дугаар өгч картын бүртгэл хөтөлнө. Тэнцлээс хассан үндсэн хөрөнгийн дугаарыг дахин олгохгүй. Үндсэн хөрөнгийг жилд нэгээс доошгүй удаа тоолж, тэнцлийн үлдэгдэл дүнтэй, зах зээлийн үнэлгээг тулгаж шалгана.

Б-9.1 ҮНДСЭН ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ

9.1.1 Үндсэн хөрөнгийг бэлтгэх, худалдан авах

Дуусаагүй барилгын санхүүжилтын хэмжээгээр:

Дебет: Үндсэн хөрөнгийн санхүүжилт (дуусаагүй барилга)
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Барилгыг ашиглалтад хүлээн авсан актыг үндэслэн барилгын өртгийн дүнгээр:

Дебет: Барилга байгууламж
Кредит: Үндсэн хөрөнгийн санхүүжилт (дуусаагүй барилга)

Байшин барилга ашиглалтад орох хүртэл хугацаанд үндсэн хөрөнгийн санхүүжилтын дансанд бүртгэж, санхүүгийн жил дамжсан актив үлдэгдэлтэй байж болно. Энэ дансаар ББСБ-

ын ТУЗ-өөс зөвшөөрөгдсөн үндсэн хөрөнгийн санхүүжилтээс өөр зүйл бүртгэхийг хатуу хориглоно.

Үндсэн хөрөнгийг худалдан авсан тохиолдолд бэлтгэн нийлүүлэгч байгууллагын нэхэмжлэлийг үндэслэн худалдан авсан өртгийн дүнгээр:

Дебет: Үндсэн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох дансд

Үндсэн хөрөнгийн үнэ, холбогдох зардлыг урьдчилж төлсөн боловч үндсэн хөрөнгийг биетээр хүлээж аваагүй бол:

Дебет: Урьдчилж төлсөн тооцоо

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох дансд

Үндсэн хөрөнгийг хүлээж авахад:

Дебет: Үндсэн хөрөнгө

Кредит: Урьдчилж төлсөн тооцоо

Үндсэн хөрөнгөнд сар тутам элэгдэл тооцохдоо:

Дебет: Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал

Кредит: Хуримтлагдсан элэгдлийн холбогдох данс

Ашиг, алдагдлын шалтгаанаар тухайн сарын үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэлийг бодохгүй байхыг хатуу хориглоно.

9.1.2 Үндсэн хөрөнгийг бусдад худалдах:

Үндсэн хөрөнгийг бусдад худалдах тохиолдолд байгуулсан элэгдлийн хэмжээгээр:

Дебет: Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл

Кредит: Үндсэн хөрөнгийн холбогдох данс гэж үндсэн хөрөнгийн анхны үнийг элэгдлийн дүнгээр хорогдуулж үлдэгдэл өртгийг гаргана.

Борлуулах үнэ нь тухайн үндсэн хөрөнгийн үлдэгдэл өртгөөс их бол:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс /борлуулсан үнээр/

Кредит: Үндсэн хөрөнгийн холбогдох данс /үлдэгдэл өртгөөр/

Кредит: Үндсэн хөрөнгийн борлуулсны орлого /давсан дүнгээр/

Борлуулах үнэ нь тухайн үндсэн хөрөнгийн үлдэгдэл үнээс бага бол борлуулсан дүнгээр:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс /борлуулсан үнээр/

Дебет: Хөрөнгө данснаас хассаны гарз /дутсан дүнгээр/

Кредит: Үндсэн хөрөнгийн холбогдох данс /үлдэгдэл өртгөөр/

9.1.3 Үндсэн хөрөнгийг ашиглалтаас хасах

Элэгдэл хорогдлоо бүрэн байгуулсан үндсэн хөрөнгийг балансаас актлан хасахдаа:

Дебет: Хуримтлагдсан элэгдэл

Кредит: Үндсэн хөрөнгө

Хэрэв элэгдэл хорогдлоо бүрэн байгуулаагүй үндсэн хөрөнгийг байгууллага тэнцлээс актлан хасахад:

Байгуулсан элэгдэл хорогдлын хэмжээгээр:

Дебет: Хуримтлагдсан элэгдэл
Кредит: Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл үнээр нь:

Дебет: Хөрөнгө данснаас хассаны гарз
Кредит: Үндсэн хөрөнгө

9.1.4 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ

Дараах тохиолдолд үндсэн хөрөнгийг дахин үнэлнэ. Үүнд:

1/ Тухайн хөрөнгө хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч цаашид үргэлжлүүлэн ашиглах боломжтой байх,

2/ Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өртөг нь цэвэр боломжит үнэ цэнээс материаллаг зөрүүтэй болсон байх,

3/ Дээрх 2-оос бусад тохиолдлоор дахин үнэлэх шаардлагатай болсон.

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг мэргэжлийн үнэлгээчид хийнэ.

Дахин үнэлгээний зөрүүг санхүүгийн тайланд дараах байдлаар харуулна. Үүнд:

Дахин үнэлгээний улмаас үндсэн хөрөнгийн үлдэгдэл өртөг /хуримтлагдсан элэгдлийг хассан/ нэмэгдсэн тохиолдолд нэмэгдсэн хэмжээгээр Өөрийн хөрөнгө хэсэгт Дахин үнэлгээний нэмэгдэл нэртэйгээр харуулна.

1/ Дахин үнэлсэн үнэ нь тухайн хөрөнгийн үлдэгдэл өртгийг илэрхийлж байгаа бол:

1.1 Хөрөнгийн ангилал тус бүрийн ашиглагдах хугацаанаас ашиглагдсан хугацааг хасч, цаашид ашиглагдах хугацааг шинэчлэн тогтоож, дахин үнэлсэн үнээс элэгдэл тооцно. Энэ тохиолдолд өмнө нь байгуулсан хуримтлагдсан элэгдлийг тэглэнэ.

Дахин үнэлэх хүртэл байгуулсан хуримтлагдсан элэгдлийн дүнгээр:

Дебет: Хуримтлагдсан элэгдэл
Кредит: Үндсэн хөрөнгө

Ажлын хэсгийн шийдвэрийн дагуу шинэ үнэлгээний дүнгээр:

Дебет: Үндсэн хөрөнгө
Кредит: Дахин үнэлгээний нэмэгдэл

1.2 Дахин үнэлэхийн өмнөх үлдэгдэл өртөг ба дахин үнэлсний дараах үлдэгдэл өртгийн харьцаагаар хөрөнгийн ангилал тус бүрийн анхны өртөг ба хуримтлагдсан элэгдлийг зэрэг нэмэгдүүлж ашиглагдах хугацааг хэвээр мөрдөнө.

Дебет: Үндсэн хөрөнгө
Кредит: Хуримтлагдсан элэгдэл
Кредит: Дахин үнэлгээний нэмэгдэл

2/ Хөрөнгийн дахин үнэлсэн үнэ нь шинэчлэн тодорхойлсон анхны өртгийг илэрхийлж байгаа бол анхны өртгийн өсөлтийн харьцаагаар хуримтлагдсан элэгдэл ба үлдэгдэл өртгийг зэрэг нэмэгдүүлнэ. Энэ тохиолдолд хийгдэх дансны гүйлгээ нь 1.2-той адил байна.

Б-10 БИЕТ БУС ХӨРӨНГӨ

1. Тодорхойлолт

Биет бус хөрөнгө - ажил үйлчилгээний нийлүүлэлтэд ашиглагдах, бусад түрээслэх буюу удирдлагын зориулалтаар ашиглахаар эзэмшиж буй биет шинж чанаргүй, харьцангуй удаан хугацаанд ашиглаж болох мөнгөн бус хөрөнгийг хэлнэ.

Биет бус хөрөнгийг олж бэлтгэхтэй холбогдсон зардлуудыг тусгайлан тодорхойлж болохоор байх ёстой.

Биет бус хөрөнгийн өртөг - тухайн хөрөнгийг бий болгох, олж эзэмших үед зарцуулагдсан мөнгө ба хөрөнгө.

Үлдэх өртөг - хөрөнгийн ашиглалтын хугацаа дууссаны дараа ББСБ-ын олж авах цэвэр мөнгөн дүн.

Биет бус хөрөнгийн хорогдол - ашиглалтын хугацаанд биет бус хөрөнгийг элэгдүүлэх зардлын системтэй хуваарилалт юм.

Хорогдлын зардал - санхүүгийн тайланд тусгагдсан хөрөнгийн өртөг эсвэл түүнийг орлох өртгөөс үлдэх өртгийг хассан дүн.

Ашиглалтын хугацаа - ББСБ-аас тухайн хөрөнгийг ашиглахаар тогтоосон хугацаа эсвэл түүнийг ашиглаж бий болгох ажил үйлчилгээний тоо хэмжээ ба түүнтэй адилтгах нэгж.

2. Хамрагдах зүйлс

Патент, гудвилл, франчайз, зохиогчийн эрх, лиценз, худалдааны тэмдэг, программ хангамж, зохион байгуулалтын зардал зэрэг хамаарна.

Биет бус хөрөнгийг дараах нөхцөлд хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Хөрөнгөтэй холбогдох ирээдүйн эдийн засгийн өгөөж нь уг ББСБ-д орж ирэх магадлалтай байх;

- Уг хөрөнгийн өртгийг хэмжиж болохоор байх.

3. Үнэлгээ

Бүх тодорхойлж болох биет бус хөрөнгийг анхны өртгөөр үнэлэх бөгөөд тодорхой хугацаанд өнөөгийн цэвэр үнэ цэнээр дахин үнэлж болно.

Хорогдуулалт: Биет бус хөрөнгийг анхны өртгөөс хорогдуулалтыг хассан дүнгээр бүртгэнэ. Биет бус хөрөнгийг түүний хүлээгдэж буй үр өгөөжит хугацаанд нь орлого үр дүнгийн тайланд үр ашгийн бууралтыг харуулах байдлаар системтэйгээр хорогдуулна.

Биет бус хөрөнгийн хорогдол тооцох өртөг нь хөрөнгийн анхны өртгөөс үлдэх өртгийг хассан дүн байна. Практикт биет бус хөрөнгийн үлдэх өртгийг ихэнхдээ тэгтэй тэнцүү гэж үздэг.

4. Санхүүгийн тайланд тусгах нь:

Биет бус хөрөнгийг балансын Хөрөнгө талд 9 дэх зүйл болгон тусгана.

5. Хяналт ба бүртгэл

Хөрөнгө бүрээр дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж, хяналтын дансны гүйлгээ, үлдэгдэлтэй тохируулна.

Хөрөнгийг жилд нэгээс доошгүй удаа тоолж тэнцлийн үлдэгдэл ба анхны өртөгтэй тулган шалгана. Биет бус хөрөнгийн талаар санхүүгийн тайланд тодруулна.

Б-10.1 БИЕТ БУС ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ

Биет бус хөрөнгийг бэлтгэх, худалдан авахад:

Дебет: Биет бус хөрөнгө
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох дансд

Биет бус хөрөнгийн тайлангийн үед ногдох хорогдуулалтын зардлын дүнгээр ХЭ-биет бус хөрөнгө дансыг нээнэ.

Дебет: Элэгдэл хорогдлын зардал
Кредит: Хуримтлагдсан элэгдэл-Биет бус хөрөнгө

Хөрөнгө бүрийн хорогдуулалтын хугацааг ББСБ бүртгэлийн бодлогоороо тогтооно.

Хорогдлоороо анхны өртгөө бүрэн нөхөөгүй үед биет бус хөрөнгийг данснаас хасвал үлдэгдэл өртгийн дүнгээр хөрөнгө данснаас хассаны алдагдал хүлээнэ.

Дебет: Хөрөнгө данснаас хассаны гарз
Кредит: Биет бус хөрөнгө

Бүртгэгдсэн биет бус хөрөнгөтэй холбогдон гарсан зардал нь тухайн биет бус хөрөнгийн ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлж байвал тэдгээр зардлыг хөрөнгийн өртөгт капиталжуулна. Бусад тохиолдолд эдгээр зардлыг тайлант үеийн зардлаар бүртгэнэ.

Биет бус хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт ба зөрүүгийн бичилт нь үндсэн хөрөнгийн бүртгэлтэй адил байна.

В - ӨР ТӨЛБӨР

1. Тодорхойлолт

Өр төлбөр гэж ББСБ-ын үйл ажиллагаагаар бий болсон бусдын өмнө хүлээсэн эдийн засгийн үүрэг, хариуцлага юм.

Өр төлбөрийг үүссэн хугацаагаар нь богино хугацаат, урт хугацаат өр төлбөр гэж ангилна.

1. Богино хугацаат өр төлбөр гэдэг нь бизнесийн үйл ажиллагааны хэвийн цикл эсвэл нэг жилийн аль уртад одоо байгаа эргэлтийн хөрөнгөөр эсвэл богино хугацаат өр төлбөр үүсгэх замаар барагдах үүрэг хариуцлага юм.
2. Урт хугацаат өр төлбөр гэдэг нь бизнесийн үйл ажиллагааны хэвийн цикл эсвэл нэг жилийн аль уртад төлөгдөхгүй буюу 1 жилийн дотор одоо байгаа эргэлтийн хөрөнгөөр барагдахгүй үүрэг хариуцлага юм.

2. Үндсэн шинж чанар

- ББСБ нь зээл болон бусад аливаа хэлбэрээр банк, санхүүгийн байгууллагаас бусад хуулийн этгээд болон иргэдээс хөрөнгө татан төвлөрүүлэх замаар өр төлбөрийг бий болгож болохгүй;
- Өнгөрсөн үйл ажиллагаанаас бий болсон одоогийн үүрэг хариуцлага оршин байх. Энэ нь өнгөрсөн хугацаан дахь ажил гүйлгээ эсвэл үйл явдлын үр дүнд гуравдагч талын өмнө хүлээх үүрэг хариуцлагыг бий болгох бөгөөд хараахан барагдаагүй зүйл;
- Тайлагнагч ББСБ-ын хувьд санхүүгийн сөрөг үр дагавартай зүйл бөгөөд ББСБ үүргээ биелүүлэхийн тулд нэмж өр төлбөр үүсгэх эсвэл нэг буюу хэд хэдэн байгууллагад мөнгө болон бусад хөрөнгөө шилжүүлэн өгөх шаардлагатай болдог.

3. Ангилал

ББСБ-ын хувьд тайлагнаж болох өр төлбөрийг дараах байдлаар ангилна. Үүнд:

- Итгэлцэл
- Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл
- Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ
- ББСБ-аас гаргасан өрийн бичиг
- Санхүүгийн үүсмэл хэрэгсэл
- Бусад эх үүсвэр
- Төслийн зээлийн санхүүжилт
- Бусад өр төлбөр зэрэг багтана.

4. Үнэлгээ

Санхүүгийн бусад эх үүсвэрийн өглөгийг ББСБ эргүүлж төлөх дүнгээр санхүүгийн тайланд бүртгэнэ. Холбогдох хөрөнгө, зардал буюу алдагдлыг хүлээн зөвшөөрсөн үед өр төлбөрийг бүртгэдэг.

5. Санхүүгийн тайланд тусгах

Өр төлбөрийн хугацаанаас нь хамаарч богино ба урт хугацаат гэсэн хэлбэртэйгээр дансанд тусгана.

В-1 ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

1. Тодорхойлолт

Итгэлцлийн үйлчилгээ гэж итгэл хүлээлгэгчийн актив /бэлэн мөнгө, зээл, бусад актив/-ыг үнэгүйдлээс хамгаалж, ашиг олж өгөх зорилгоор тэдгээртэй харилцан тохиролцсон гэрээний үндсэн дээр итгэл хүлээгчээс нэр бүхий активыг түр хугацаанд хянах, ашиглах, захиран зарцуулах үйл ажиллагааг хэлнэ.

2. Үнэлгээ

Итгэлцлийн үйлчилгээний өглөгийг гэрээнд заасны дагуу нэрлэсэн үнээр нь бүртгэнэ.

3. Санхүүгийн тайланд тусгах нь

Итгэлцлийн үйлчилгээг санхүүгийн тайланд бүртгэхдээ тэнцлийн Өр төлбөр талд санхүүгийн зарим эх үүсвэр хэсэгт бүртгэнэ. Итгэлцлийн үйлчилгээний зардлыг гэрээний хугацаа дуусгавар болсон нөхцөлд хоёр тал гэрээг дүгнэж тооцоо хийнэ.

4. Хяналт ба бүртгэл

Итгэлцлийн үйлчилгээний өглөгийг дансдын байршил, үлдэгдлийн хэмжээ, төлөгдөх хугацаа зэргийг зохистой хэмжээнд байлгана. Дэлгэрэнгүй бүртгэлийг дансны гүйлгээ, үлдэгдэлтэй тохируулна.

Итгэлцлийн үйлчилгээнд баримтлах бодлогын талаар санхүүгийн тайланд тодруулга хийнэ. Итгэлцлийн үйл ажиллагаанд тэнцлийн дансдын туслах журнал хөтөлж, гүйлгээг үндсэн баримт, нэрийн данс бүрээр тулган шалгаж тогтсон хугацаанд нийлж тохируулна.

В-1.1 ИТГЭЛЦЛИЙН БҮРТГЭЛ

ББСБ нь харилцан тохиролцсон гэрээний үндсэн дээр итгэл хүлээлгэгчийн актив /бэлэн мөнгө, зээл, бусад актив/-ыг түр хугацаанд хянах, ашиглах, захиран зарцуулах тохиолдолд дараах бичилтийг хийнэ.

Итгэлцлийн гэрээний дагуу өгөх өглөг:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс, зээлийн холбогдох данс эсвэл бусад активын холбогдох данс

Кредит: Итгэлцлийн үйлчилгээний өглөг

Итгэлцлийн үйлчилгээний гэрээний хугацаа дуусгавар болсон тохиолдолд хоёр тал гэрээний хэрэгжилтийг дүгнэн дараах бичилтийг хийнэ.

Дебет: Итгэлцлийн үйлчилгээний зардлын данс

Дебет: Итгэлцлийн үйлчилгээний өглөг

Кредит: Мөнгөн хөрөнгийн данс, зээлийн холбогдох данс эсвэл бусад активын холбогдох данс

В-2 БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС АВСАН ЗЭЭЛ

1. Хамрагдах зүйлс

ББСБ нь зөвхөн Банк, санхүүгийн байгууллагаас зээл авч болох бөгөөд тэдгээрт төлөх өглөгт дараах зүйлс орно. Үүнд:

- Банкны байгууллагаас авсан төгрөг, гадаад валютын зээл
- Бусад санхүүгийн байгууллагаас авсан төгрөг, гадаад валютын зээл

2. Үнэлгээ

Банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөгийг ББСБ эргүүлж төлөх дүнгээр нь бүртгэнэ.

Бусдад төлөх өглөгийн хүүг ББСБ сар бүр хуримтлуулан тооцож тухайн тайлант хугацааны зардлаар бүртгэнэ.

3. Санхүүгийн тайланд тусгах нь:

Банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөгийг балансын Өр төлбөр талд 2 дахь зүйл болгон тусгана.

ББСБ нь гадаадын санхүүгийн байгууллагаас авсан зээлийг эргүүлэн төлөх тохиолдолд Монголбанкнаас зарласан ханшаар тооцож төгрөгт хөрвүүлэн төгрөг, гадаад валютаар давхар бүртгэх ба ханшийн тэгшитгэлээс гарах орлого, зарлагыг тайлант хугацааны цэвэр орлогод оруулна.

4. Хяналт ба бүртгэл

Бусдад төлөх өглөгийн дансдаар туслах журнал хөтөлж, гүйлгээг үндсэн баримттай нь тулган шалгана. Баримт материал, түүнтэй холбогдох файлын хадгалалт, хамгаалалт, найдвартай байдлыг хангана. Бусдад төлөх өглөгийн дансдын үлдэгдлийг нийлж тохируулна.

В-2.1 ЗЭЭЛИЙН БҮРТГЭЛ

Банк, санхүүгийн байгууллагаас зээл авсан тохиолдолд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс
Кредит: Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн данс

Зээлийг буцаан төлөх тохиолдолд:

Дебет: Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

Зээлийн хүүг хуримтлуулан тооцоход:

Дебет: Зээлийн хүүгийн зардал
Кредит: Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн өглөг

Зээлийн хүүгийн төлбөрийг төлөх нөхцөлд:

Дебет: Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн өглөг
Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

В-3 ЦАХИМ ТӨЛБӨР ТООЦОО, МӨНГӨН ГУЙВУУЛГЫН ҮЙЛЧИЛГЭЭ

1. Тодорхойлолт

Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ гэж бусдын мөнгөн хөрөнгийг банкин дахь өөрийн харилцах дансаар дамжуулан шилжүүлэх, эсвэл интернет, автомат тоног төхөөрөмж, цахим төлбөр тооцооны хэрэгсэл ашиглаж, төлбөр тооцоог гүйцэтгэх ажиллагааг хэлнэ.

2. Үнэлгээ

Цахим төлбөр тооцооны хэрэгслийг тэнцлийн гадуур дансанд нэрлэсэн үнээр нь бүртгэнэ. Мөнгөн гуйвуулгын төлбөрийг тайланд нэрлэсэн үнээр нь бүртгэнэ.

3. Санхүүгийн тайланд тусгах нь

Мөнгөн гуйвуулгын үйлчилгээг балансын Өр төлбөр талд Бусад эх үүсвэр хэсэгт бүртгэнэ.

4. Хяналт ба бүртгэл

Мөнгөн гуйвуулгын гүйлгээг журмын дагуу үндсэн баримттай тулган шалгаж тогтсон хугацаанд нийлж тохируулна. Цахим төлбөр тооцоогоор хийгдэх гүйлгээг холбогдох хууль, тогтоомж, заавар журмын дагуу хийнэ.

В-3.1 ЦАХИМ ТӨЛБӨР ТООЦОО, МӨНГӨН ГУЙВУУЛГЫН БҮРТГЭЛ

Цахим төлбөр тооцооны хэрэгслээр дамжуулан төлбөр тооцоог гүйцэтгэж болох бөгөөд дансны бичилтийг доорх байдлаар тусгана.

Цахим төлбөр тооцооны хэрэгслээр хийгдэх гүйлгээг бүртгэхдээ :

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс

Кредит: Төлбөрийн болон зээлийн картын үйлчилгээтэй холбоотой өглөг

ББСБ нь автомат тоног төхөөрөмж, цахим төлбөр тооцооны хэрэгслээр дамжуулан төлбөр тооцоог гүйцэтгэх үйлчилгээний шимтгэлийг бүртгэхдээ:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс

Кредит: Картын үйлчилгээний орлого

ББСБ нь автомат тоног төхөөрөмж, цахим төлбөр тооцооны хэрэгслээр дамжуулан мөнгөн хөрөнгийг буцааж бүртгэхдээ:

Дебет: Төлбөрийн болон зээлийн картын үйлчилгээтэй холбоотой өглөг

Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

Гуйвуулгаар мөнгөн хөрөнгө шилжиж ирсэн гүйлгээг бүртгэхдээ:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс

Кредит: Мөнгөн гуйвуулгын өглөг

ББСБ нь банк болон бусад санхүүгийн байгууллага дахь өөрийн харилцах дансаар дамжуулан мөнгөн гуйвуулгын үйлчилгээг үзүүлсний шимтгэлийг бүртгэхдээ:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс

Кредит: Мөнгөн гуйвуулгын орлого

Гуйвуулгаар шилжиж ирсэн мөнгөн хөрөнгийг буцаан шилжүүлэхэд:

Дебет: Мөнгөн гуйвуулгын өглөг

Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

В-4 ББСБ-аас гаргасан өрийн бичиг

1.Тодорхойлолт

ББСБ-аас гаргасан өрийн бичиг гэж шаардлагатай эх үүсвэрийг татан төвлөрүүлэх зорилгоор тодорхой хугацааны дараа үндсэн төлбөр болон хүүг эргүүлэн төлөх нөхцөлтэйгээр гаргасан өрийн бичгийг хэлнэ.

ББСБ-аас гаргасан өрийн бичиг гэдэг нь ББСБ-аас гаргасан 1 жил хүртэлх хугацаатай өрийн бичгийг хэлнэ.

2. Үнэлгээ

ББСБ-аас гаргасан өрийн бичгийг нэрлэсэн үнээр нь бүртгэнэ.

3. Санхүүгийн тайланд тусгах

ББСБ-аас гаргасан өрийн бичгийг хуулийн хувьд хүчин төгөлдөр гэрээ, хэлцлээр баталгаажсан нөхцөлд санхүүгийн тайлан тэнцэлд тусгана.

ББСБ-аас гаргасан өрийн бичгийг балансын Өр төлбөр талд 4 дэх зүйл болгон тусгана.

4. Хяналт ба бүртгэл

ББСБ-аас өрийн бичгийг Хорооноос зөвшөөрөл авсны дагуу гаргаж болно.

ББСБ-аас гаргасан өрийн бичгийг “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”, “Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх тухай журам”-ын дагуу бүртгэж, хяналт тавина.

В-4.1 ӨРИЙН БИЧГИЙН БҮРТГЭЛ

ББСБ нь өрийн бичиг гаргаж эх үүсвэр татахад:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс
Кредит: Өрийн бичгээрх өглөг

Өрийн бичгийг эзэмшигч буцаан мөнгөжүүлэхэд үндсэн дүнгээр:

Дебет: Өрийн бичгээрх өглөг
Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

Төлөх хүүгийн дүнгээр:

Дебет: Өрийн бичгийн хүүгийн зардал
Кредит: Хуримтлуулж тооцсон өрийн бичгийн хүүгийн өглөг

Төлсөн хүүгийн дүнгээр:

Дебет: Хуримтлуулж тооцсон өрийн бичгийн хүүгийн өглөг
Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

В-5 ТӨСЛИЙН ЗЭЭЛИЙН САНХҮҮЖИЛТ

1. Тодорхойлолт

Эрх бүхий этгээдээс тусгайлан олгосон эрхийн /тендер/ дагуу банк, ББСБ-аар гэрээний үндсэн дээр дамжуулан олгох зээлийн эх үүсвэрийг ойлгоно.

Төслийн зээлийн санхүүжилтыг тэнцэлд эргүүлж төлөх хугацаанаас нь хамаарч богино болон урт хугацаат төслийн зээлийн санхүүжилт гэж ангилна.

2. Санхүүгийн тайланд тусгах нь

Төслийн зээлийн санхүүжилтыг тэнцлийн пассив талд нэрлэсэн үнээр нь бүртгэнэ.

Төслийн зээлийн өглөг болон зээлийн хүүгийн тооцоог гэрээнд заагдсан хугацаанд төлж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах ба тогтоосон хугацаанд гэрээг дүгнэж байх.

В-5.1 ТӨСЛИЙН ЗЭЭЛИЙН САНХҮҮЖИЛТЫН БҮРТГЭЛ

ББСБ нь төслийн зээлийн санхүүжилт авах үед:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс
Кредит: Төслийн зээлийн санхүүжилт

Төслийн зээлийн хүүг хуримтлуулж тооцох үед:

Дебет: Төслийн зээлийн санхүүжилтын хүүгийн зардал
Кредит: Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөгийн холбогдох данс

Хүүг төлөх үеийн дансны бичилт:

Дебет: Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөгийн холбогдох данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

Төслийн зээлийн санхүүжилтыг гэрээний дагуу төлөх үед:

Дебет: Төслийн зээлийн санхүүжилт
Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

В-6 БУСАД ӨР ТӨЛБӨР

1. Тодорхойлолт

Бусад өр төлбөр гэж ББСБ-ын хувьд үндсэн бус үйл ажиллагааны үр дүнд бусад байгууллага, иргэдийн өмнө хүлээх үүрэг хариуцлагыг хэлнэ.

Бусад өр төлбөрт дараах зүйлс орно. Үүнд:

- Салбар хоорондын тооцооны өглөг
- Нийгмийн даатгал
- Эрүүл мэндийн даатгал
- Орлогын ба ХАОАТ-ын өглөг
- Цалингийн өглөг
- Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг
- Бусад

Бусад өр төлбөрт аливаа хэлбэрээр иргэд, бусад хуулийн этгээдээс эх үүсвэр болгон татан төвлөрүүлсэн хөрөнгийг тусгахыг хориглоно.

2. Үнэлгээ

Бусад өр төлбөрийг нэрлэсэн үнээр нь бүртгэнэ.

3. Санхүүгийн тайланд тусгах нь

Бусад өр төлбөрийг балансын Өр төлбөр талд 7 дахь зүйл болгон тусгана.

4. Хяналт ба бүртгэл

Бусад өр төлбөрийн дансдаар туслах журнал хөтөлж, гүйлгээг үндсэн баримттай нь тулган шалгаж, дансны үлдэгдлийг нийлж тохируулна.

Бусад пассивын дансдын гүйлгээнд байгууллагын дотоод хяналтын албанаас тогтмол хяналт тавина.

В-6.1 БУСАД ӨР ТӨЛБӨРИЙН БҮРТГЭЛ

Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг, татварын өглөг, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал, цалингийн өглөг, бусад өглөгийн дансдыг тооцоо үүссэн тухай бүр зохих дансдад бичилт хийж байна.

Байгууллагын орлогын албан татварын (цаашид ОАТ гэх) өглөгийг тооцож бүртгэх:

Дебет: Орлогын албан татварын зардал

Кредит: Орлогын албан татварын өглөг

Байгууллагын орлогын албан татвар төлөгдөх үед:

Дебет: Орлогын албан татварын өглөг

Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын тооцоо үүсэх үед:

Дебет: Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал

Кредит: Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын өглөг

Эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалын тооцоо төлөгдөх үед:

Дебет: Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын өглөг

Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

Бараа материал, бусад хөрөнгө, ажил үйлчилгээг зээлээр худалдан авахад:

Дебет: Хөрөнгийн холбогдох данс

Кредит: Бусад өглөг

Бараа, материал, бусад хөрөнгө, ажил, үйлчилгээний үнийг төлөхөд:

Дебет: Бусад өглөг

Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

Тайлант үеийн эцэст нягтлан бодох бүртгэлийг аккрузал суурийн дагуу зардал хуримтлуулж бүртгэхэд:

Дебет: Холбогдох зардлын данс

Кредит: Бусад өглөг

Хуримтлуулсан өглөгийг мөнгөөр төлөхөд:

Дебет: Бусад өглөг

Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

Ногдол ашгийг хуваарилахад өнгөрсөн жилийн цэвэр ашгаас хуваарилах бөгөөд нягтлан бодох бүртгэлийн дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Дебет: Өнгөрсөн жилийн цэвэр ашиг

Кредит: Ногдол ашгийн өглөг

Ногдол ашгийг олгоход дараах бичилтийг хийнэ.

Дебет: Ногдол ашгийн өглөг

Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

Г- ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

1. Тодорхойлолт

Эзэмшигчдийн өмч буюу капитал нь оруулсан капитал болон олсон капиталын нийлбэр юм. Эзэмшигчдийн өмч нь ББСБ-ын нийт хөрөнгийн дүнгээс өр төлбөрийг хассан дүнтэй тэнцүү байна.

Оруулсан капитал нь аливаа хугацаанд капитал өмчийн хувьцаанд төлсөн буюу өөр ямар нэг байдлаар бизнест ашиглахын тулд хувьцаа эзэмшигчдийн ББСБ-д оруулсан хөрөнгийн нийт дүнг хэлнэ. Оруулсан капиталд эргэлтэнд байгаа өмчийн хувьцааны нэрлэсэн үнэ, гаргалтын аливаа хөнгөлөлтийг хассан цэвэр урамшуулал, захиалгын гэрээгээр төлсөн дүн зэрэг зүйлс багтана.

Олсон капитал нь ББСБ ашигтай үйл ажиллагаа явуулсны үр дүнд нэмэгдсэн капитал. Энэ нь тухайн ББСБ-ын хуваарилагдаагүй нийт орлого юм.

Хувьцаа нь ББСБ-д хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн, санал өгөх, ногдол ашиг авах, ББСБ-ыг татан буулгахад түүний эд хөрөнгөөс тодорхой хэсгийн өмчлөх эрхийг гэрчилж буй үнэт цаас.

Хувьцаат капитал нь худалдагдсан хувьцааны нэрлэсэн үнийн дүн.

Нэмж төлөгдсөн капитал нь хувьцааны нэрлэсэн үнээс илүү төлөгдсөн хэмжээг хэлнэ. Хувьцааг нэрлэсэн үнээс доогуур үнээр борлуулбал хүлээсэн алдагдлыг нэмж төлөгдсөн капиталын дансанд сөрөг тэмдэгтэйгээр харуулна.

Хуримтлагдсан ашиг нь үйл ажиллагаа эхэлсэн үеэс нэмэгдсэн капитал юм. Энэ нь тухайн тайлангийн хугацаанд олсон цэвэр ашгийн хэмжээгээр нэмэгдэж, алдагдлын хэмжээгээр буурна.

2. Хамрагдах зүйлс

- Хувьцаа /ердийн болон давуу эрхтэй хувьцаа/,
- Халаасны хувьцаа,
- Нэмж төлөгдсөн капитал,
- Дахин үнэлгээний нэмэгдэл,
- Хандивын капитал
- Нөөцийн сан,
- Нийгмийн хөгжлийн сан,
- Тухайн жилийн ашиг, алдагдал,
- Хуримтлагдсан ашиг, алдагдал,
- Хоёрдогч өглөг /5-аас дээш жилийн хугацаатай/.

3. Үнэлгээ

Эзэмшигчийн өмчийг нэрлэсэн үнээр нь бүртгэнэ.

4. Санхүүгийн тайланд тусгах нь

Эзэмшигчийн өмчийг балансад Эзэмшигчийн өмч бүлэгт тусад нь ангилж харуулна.

5. Хяналт ба бүртгэл

Хорооноос тогтоосон өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт цэвэршүүлсэн активын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллана. Эзэмшигчийн өмчийн дансны үлдэгдлийг тогтмол нийлж тохируулна.

Хувьцаа эзэмшигч тус бүрээр дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж, хяналтын дансны гүйлгээ үлдэгдэлтэй тохируулна. Нөөцийн сангийн зарцуулалтыг ББСБ-ын хувь нийлүүлэгчдийн хурлаар батална.

Санхүүгийн жилийн ашгаас өөрийн нэр дээр болон тодорхойгүй дансанд хөрөнгө хуваарилахыг хориглоно. ББСБ нь дүрмийн санг мөнгөн хөрөнгөөр бүрдүүлэх бөгөөд Хорооноос тогтоосон дүрмийн сангийн доод хэмжээг хангасан байна.

ББСБ-ын дүрмийн сангийн хэмжээ, бүтэц, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд Хороонд мэдэгдэж, холбогдох зөвшөөрөл авсны дагуу бүртгэлд тусгаж болно.

Г-1 Хувьцаат капиталын бүртгэл

Хувь нийлүүлэгчдээс ББСБ-д хувьцаагаар хөрөнгө оруулах ба хувьцаа нь энгийн болон давуу эрхтэй гэсэн хэлбэртэй байна.

Нээлттэй хэлбэрээр зохион байгуулагдсан ББСБ-ын хувьд үнэт цаас гаргаж нийтэд санал болгох, худалдах ажиллагаа нь Монгол Улсын "Үнэт цаасны тухай хууль", бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдэх ба нягтлан бодох бүртгэлийг НББОУС болон Монгол Улсад мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн зарчмын дагуу гүйцэтгэнэ.

Хувьцаа нь ББСБ-ын дүрмээр тогтоосон нэрлэсэн үнэтэй байх ба нэрлэсэн үнэгүй байж болно. Нэрлэсэн үнэгүй хувьцааг арилжааны явцад тодорхойлогдсон ханшийг үндэслэн үнэлж бүртгэнэ.

ББСБ-ын удирдлагын эрх бүхий субъектын шийдвэр, Хорооны зөвшөөрлийг үндэслэн хувь нийлүүлэгчдээс ББСБ-д хөрөнгө оруулахад:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс
Кредит: Энгийн /давуу эрхтэй/ хувьцаа

Хувьцааг нэрлэсэн ба тогтоосон үнээс илүү үнээр борлуулбал:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс (борлуулсан үнээр)
Кредит: Энгийн /давуу эрхтэй/ хувьцаа (нэрлэсэн үнээр)
Кредит: Нэмж төлөгдсөн капитал (үнийн зөрүүгээр)

Монгол Улсын "Компанийн тухай хууль"-аар нэрлэсэн үнэтэй хувьцааг түүнээс доош үнээр борлуулахыг хориглодог.

Нээлттэй хэлбэрээр зохион байгуулагдсан ББСБ хувьцаагаа зах зээлээс эргүүлэн худалдан авахад "Халаасны хувьцаа" дансанд бүртгэнэ.

Хувьцаа худалдан авсны дараа эргэлтээс гаргах эсвэл дахин борлуулах зорилгоор халаасны хувьцаа байдлаар эзэмшиж болно. Хэрэв эргэлтээс гаргаагүй бол ийм хувьцааг халаасны хувьцаа гэнэ.

Худалдан авсан халаасны хувьцааг худалдан авсан үнэ буюу өртгөөр нь:

Дебет: Халаасны хувьцаа
Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

Халаасны хувьцааг өртгөөс нь дээгүүр үнээр дахин гүйлгээнд гаргасан бол:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс
Кредит: Халаасны хувьцаа
Кредит: Нэмж төлөгдсөн капитал

Халаасны хувьцааг өртгөөс нь доогуур үнээр дахин гүйлгээнд гаргасан бол:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс
Дебет: Нэмж төлөгдсөн капитал
Дебет: Хуримтлагдсан ашиг
Кредит: Халаасны хувьцаа

Г-2 Хандивын капиталын бүртгэл

Хоёр улсын засгийн газрын шугамаар хандивлагч орон, донор байгууллагаас буцалтгүй тусламжаар орж ирсэн хөрөнгийн эх үүсвэрийг гэрээний үндсэн дээр хандивын капитал дансад бүртгэнэ.

Хандивын хөрөнгийг санхүүгийн тайланд тусгахын өмнө Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэж, холбогдох зөвшөөрлийг авсан байна.

Мөнгөөр орж ирсэн тохиолдолд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс
Кредит: Хандивын капитал

Хөрөнгөөр орж ирсэн тохиолдолд:

Дебет: Хөрөнгийн холбогдох данс
Кредит: Хандивын капитал

Г-3 Хуримтлагдсан ашгийн бүртгэл

Тайлант жилийн эцэст ББСБ, түүний салбарууд хаалтын гүйлгээ хийж, тухайн жилийн цэвэр ашиг, алдагдлыг тодорхойлно.

Тайлант үеийн болон өмнөх үеийн хуримтлагдсан ашгийг тусад нь нэрийн дансаар бүртгэж болно.

Г-4 Ашгийн хуваарилалтын бүртгэл

ББСБ-ын хувь нийлүүлэгчдийн хурал ба удирдлагын бусад субъектээс тайлант жилийн цэвэр ашгийг хуваарилах шийдвэр гаргаж, Хорооноос зөвшөөрөл авна.

Санхүүгийн жилийн ашгаас гишүүдэд ногдол ашиг хуваарилахад дүрмийн санд нийлүүлсэн мөнгөн хөрөнгийн эзлэх хувь, дүрмийн санд анх бүртгэгдсэн хоногийг харгалзана.

ББСБ нь ногдол ашгийг хуваарилахад дараах байдлаар бүртгэнэ.

Дебет: Өнгөрсөн жилийн цэвэр ашиг

Кредит: Ногдол ашгийн өглөг

Ногдол ашгийг мөнгөөр олгоход:

Дебет: Ногдол ашгийн өглөг

Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

Хувь нийлүүлэгчид нь хуваарилагдсан ногдол ашгаар өөрийн эзэмшлийн хувьцааг нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн бол Хорооноос зөвшөөрөл авсны дагуу дараах бичилтийг хийнэ.

Дебет: Өнгөрсөн жилийн цэвэр ашиг

Кредит: Ногдол ашгийн өглөг

Дебет: Ногдол ашгийн өглөг

Кредит: Энгийн /давуу эрхтэй/ хувьцаа

Жилийн цэвэр ашгаас ББСБ-ын нөөцийн сан, нийгмийн хөгжлийн сан, болон бусад тусгай зориулалтын сангуудад хөрөнгө хуваарилахаар шийдвэрлэсэн бол хуваарилах хөрөнгийн дүнгээр:

Дебет: Өнгөрсөн жилийн цэвэр ашиг

Кредит: Сангийн холбогдох данс

Нөөцийн сан нь ББСБ-ыг бэхжүүлэхэд чиглэгдэх бөгөөд уг санг ББСБ-ын хувь нийлүүлэгчдийн хурлаас баталсан жил бүрийн санхүүгийн жилийн ашгаас тодорхой хувиар тооцож бүрдүүлнэ. Нөөцийн санг байгуулсан дүнгээр:

Дебет: Өнгөрсөн жилийн цэвэр ашиг

Кредит: Нөөцийн сангийн данс

Нийгмийн хөгжлийн санг цэвэр ашгаас байгуулж бүртгэлд тусгахдаа:

Дебет: Өнгөрсөн жилийн цэвэр ашиг
Кредит: Нийгмийн хөгжлийн сангийн данс

Нийгмийн хөгжлийн сангаас зарцуулах бол:

Дебет: Нийгмийн хөгжлийн сангийн данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

Г-5 Хоёрдогч өглөгийн бүртгэл

Гэрээнд заасан хугацаа дууссаны эцэст хувь үнийг үндийн хурлын шийдвэрийг үндэслэн хувьцаагаар солих болзолтой эх үүсвэрийг ББСБ -ын өөрийн хөрөнгөд оруулж балансад Хоёрдогч өглөгийн дансанд бүртгэнэ.

/Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 01 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс
Кредит: Хоёрдогч өглөг

Хоёрдогч өглөгийг санхүүгийн тайланд тусгахын өмнө Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэж, холбогдох зөвшөөрлийг авсан байна.

Хоёрдогч өглөгийн үндсэн өрийг ББСБ-ыг татан буулгасан, ББСБ-ыг байгуулах зөвшөөрлийг хүчингүй болгосон, дампуурсан, төлбөрийн чадваргүй болсныг зарласан, өөрчлөн байгуулсан, Хорооноос урьдчилан зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд хугацаанаас нь өмнө барагдуулахыг хориглоно.

Д - ОРЛОГО БА ЗАРДАЛ

Д – 1 ОРЛОГО БА ОЛЗ

1. Тодорхойлолт

Орлого ба олз гэдэг нь ББСБ-ын үйл ажиллагааны явцад тайлант хугацаанд бий болсон хөрөнгийн дотогш урсгал, өр төлбөр барагдуулалт болон өмчийн өсөлт хэлбэрээр эдийн засгийн өгөөж нэмэгдэхийг хэлнэ.

Орлого нь өөртөө үйл ажиллагааны орлого болон бусад орлогыг хамааруулна. ББСБ-ын үндсэн үйл ажиллагааны явцад үүсэх өгөөж нь үндсэн үйл ажиллагааны орлого болно.

Бусад орлого ба олз гэдэг нь ББСБ-ын байнгын бус гэнэтийн ажил үйлчилгээнээс түүнчлэн хувь нийлүүлэгчдийн орлого, хөрөнгө оруулалтаас бусад тухайн тайлант хугацаанд ББСБ-д нөлөөлөх бүх ажил гүйлгээ, үйл явдлын үр дүнд өмчид гарсан цэвэр өсөлт юм.

2. Орлого хүлээн зөвшөөрөх, хэмжих

Орлогын бүртгэлийн гол асуудал бол орлогыг хүлээн зөвшөөрөх цаг үеийг тодорхойлох асуудал юм. Эдийн засгийн ирээдүйн өгөөжийг тухайн байгууллага хүртэх бүрэн магадлалтай, тэрчлэн уг өгөөжийг үнэн бодитойгоор тодорхойлох боломжтой байгаа нөхцөлд орлогыг хүлээн зөвшөөрнө.

Орлогыг хүлээн авсан эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй нөхөлтийн зах зээлийн үнээр хэмжигдэнэ.

3. Орлогын ангилал

Орлого ба олзыг агуулгаас нь хамааруулж:

- А. Үндсэн үйл ажиллагааны
- Б. Үндсэн бус үйл ажиллагааны
- В. Ердийн бус гэж ангилна.

Д-1.1 ОРЛОГО БА ОЛЗЫН БҮРТГЭЛ

А. Үндсэн үйл ажиллагааны орлого

Үндсэн үйл ажиллагааны орлого нь хугацаандаа байгаа ба хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн, харилцах, хадгаламжийн дансны хүүгийн, үнэт цаасны, хугацаандаа байгаа ба хугацаа хэтэрсэн факторингийн үйлчилгээний хүүгийн, гадаад валютын ханшийн тэгшитгэлийн, үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн, гадаад валютын арилжааны, үнэт цаасны арилжааны, итгэлцлийн үйлчилгээний, мөнгөн гуйвуулгын ба үйлчилгээний хураамж, шимтгэлийн болон хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгсний хураамжийн орлого зэргээс бүрдэнэ.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг дотор нь (1) хүүгийн, (2) хүүгийн бус орлого, (3) бусад гэж ангилна.

Хүүгийн орлого нь тодорхой гэрээний үндсэн дээр зээлдэгчдэд олгосон зээл, бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгөд тэдгээрийг ашиглуулсны төлөө авч буй хариу төлбөр юм. Хүүгийн орлогыг нягтлан бодох бүртгэлийн аккрузал сууриар бүртгэнэ.

Хүүгийн бус орлогод зээлдэгчдээс авсан үйлчилгээний шимтгэл, хураамж, арилжаа болон ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого орно.

Үйлчилгээ үзүүлснээс орох орлогыг ихэнхдээ уг үйл явдал болсон тэр үед нь орлогоор хүлээн зөвшөөрнө.

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс эсвэл авлага
Кредит: Үндсэн бус үйл ажиллагааны орлого

Гадаад валютын ханш өөрчлөгдөх тухай бүрд гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгийн дансдын хуучин, шинэ үнэлгээний зөрүүгээр:

Дебет: Гадаад валютаар илэрхийлэгдэх бүх хөрөнгө
Кредит: Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого

Б. Үндсэн бус үйл ажиллагааны орлого

Үндсэн бус үйл ажиллагааны орлогод хангамжийн зориулалттай нэгжүүдээс орох орлого, үндсэн хөрөнгө, бусад хөрөнгө борлуулсны орлого, ногдол ашгийн орлого, төрөл бүрийн алданги болон гэнэтийн ажил гүйлгээнээс орох орлого орно.

Туслах аж ахуйн орлогыг бүртгэхэд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс
Кредит: Үндсэн бус үйл ажиллагааны орлого

Үндсэн хөрөнгө борлуулсны орлогыг бүртгэхэд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс
Кредит: Үндсэн хөрөнгө борлуулсны орлого

Хүлээн авсан ногдол ашгийг бүртгэхэд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс
Кредит: Ногдол ашгийн орлого

Д-2 ЗАРДАЛ БА ГАРЗ

1. Тодорхойлолт

Зардал ба гарз гэдэг нь үндсэн үйл ажиллагааг байнга явуулахын тулд бусад үйл ажиллагааг гүйцэтгэснээр хөрөнгө буурч өр төлбөр үүсэх явдал юм.

Зардал нь өөртөө үйл ажиллагааны зардал болон бусад зардал, гарзыг хамааруулна. ББСБ-ын үндсэн үйл ажиллагааны явцад үүсэх үр ашгийн бууралт нь үйл ажиллагааны зардал болно.

Бусад зардал ба гарз нь ББСБ-ын байнгын бус буюу гэнэтийн ажил гүйлгээнээс түүнчлэн эздийн зардал буюу өгсөн хуваарилалтаас бусад тухайн тайлант хугацаанд ББСБ-д нөлөөлөх бүх ажил гүйлгээ, үйл явдлын үр дүнд өмчид гарсан бууралт юм.

2. Зардлыг хүлээн зөвшөөрөх

Эдийн засгийн үр ашгийн бууралт нь хөрөнгийн үнэлгээг бууруулах буюу өр төлбөрийг нэмэгдүүлж байгаа бөгөөд хэмжиж болохуйц байвал зардлыг хүлээн зөвшөөрнө.

3. Зардлын ангилал

Зардлыг доорх байдлаар ангилж орлогын тайланд тусгана.

- А. Үндсэн үйл ажиллагааны зардал
- Б. Үндсэн бус үйл ажиллагааны зардал ба гарз
- В. Татварын зардал
- Г. Ердийн бус зардал гэж ангилна.

Д-2.1 ЗАРДАЛ БА ГАРЗЫН БҮРТГЭЛ

А. Үндсэн үйл ажиллагааны зардал

Үндсэн үйл ажиллагааны зардалд банк, бусад санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн, төслийн зээлийн санхүүжилтын хүүгийн, факторингийн болон итгэлцлийн үйлчилгээний, гадаад валютын ханшийн тэгшитгэлийн болон арилжааны, үнэт цаасны үнэлгээний тэгшитгэл болон арилжааны, шимтгэлийн болон хүүгийн зардлын буцаалт зэрэг орно.

Үндсэн үйл ажиллагааны зардлыг дотор нь (1) хүүгийн зардал, (2) хүүгийн бус, (3) бусад гэж ангилна.

1. Хүүгийн зардал нь ББСБ-ын үйл ажиллагааны эх үүсвэрт ашиглахын тулд бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн төлбөр буюу өртөг юм. Хүүгийн зардлыг татан төвлөрүүлсэн хөрөнгийн төрлөөр ангилж бүртгэнэ.

2. Хүүгийн бус зардалд хүүгийн зардлаас бусад ББСБ-ын үндсэн үйл ажиллагаатай холбогдон гарч байгаа үйлчилгээ, маркетинг, удирдлагын зардал орно.

Үйл ажиллагааны бусад зардлыг зардлын төрлөөр ангилж бүртгэнэ.

Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрт төлсөн хүүгийн зардлын бүртгэлийн зааврыг тухайн эх үүсвэр бүрийн бүртгэлийн зааварт тусгасан болно.

Зардал шууд мөнгөөр төлөгдвөл:

Дебет: Холбогдох зардлын данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

Зээлээр ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх буюу мөнгөөр төлөгдөөгүй боловч нягтлан бодох бүртгэлийн аккрузал сууриар тайлант хугацаанд ногдох зардлыг хуримтлуулж бүртгэхэд:

Дебет: Холбогдох зардлын данс
Кредит: Холбогдох өглөгийн данс

Зээлээр гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний үнэ буюу хуримтлуулж бүртгэсэн зардлыг мөнгөөр төлөх үед:

Дебет: Холбогдох өглөгийн данс
Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

Гадаад валютын ханш өөрчлөгдөх тухай бүрд гадаад валютаар илэрхийлэгдсэн өр төлбөрийн дансдын хуучин, шинэ үнэлгээний зөрүүгээр:

Дебет: Ханшийн тэгшитгэлийн зардал
Кредит: Гадаад валютаар илэрхийлэгдэх бүх өр төлбөр

Цалин, хөнгөлөлт, нийгмийн даатгалын зардал

ББСБ нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үндсэн болон түр ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулж түүнд тодорхойлсон цалинг тухай бүр тооцож олгох ба ингэхдээ татвар, шимтгэлийн тооцоог хийж холбогдох татвар санхүүгийн байгууллагуудад төлж, тайлагнах ёстой.

Цалин, олговрыг тооцооны хүснэгт, бусад баримтыг үндэслэн олгохоор тооцсон дүнгээр:

Дебет: Цалингийн зардал
Кредит: Цалингийн өглөг

Даатгуулагчаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн дүнгээр:

Дебет: Цалингийн өглөг
Кредит: Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг

Цалингаас суутгах хүн амын орлогын албан татварын (ХАОАТ) дүнгээр:

Дебет: Цалингийн өглөг
Кредит: ХАОАТ-ын өглөг

Эдгээр болон бусад суутгалуудыг хийсний дараа гарт олгох дүнгээр:

Дебет: Цалингийн өглөг
Кредит: Касс дахь бэлэн мөнгө

Үндсэн болон түр гэрээт ажиллагсад, хувь хүнд олгосон ажлын хөлс, худалдаж авсан бараа, үйлчилгээний үнээс суутгасан хүн амын орлогын татварыг харьяа татварын байгууллагад шилжүүлж:

Дебет: ХАОАТ-ын өглөг
Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

ББСБ Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үндсэн болон түр гэрээт ажиллагсдад олгосон цалин, хөнгөлөлтөөс тооцсон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг бүртгэхэд:

Дебет: ЭМД, НДШ-ийн зардал
Кредит: ЭМД, НДШ-ийн өглөг

Олгосон цалин, хөнгөлөлтөөс суутгасан болон тэдгээрээс тооцож байгууллагын зардлаар бүртгэсэн нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг харьяа нийгмийн даатгалын байгууллагад төлөхөд:

Дебет: ЭМД, НДШ-ийн өглөг
Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

ББСБ-аас Санхүүгийн зохицуулах хороонд төлөх зохицуулалтын үйлчилгээний хураамжийг тооцон бүртгэхэд:

Дебет: Зохицуулалтын хураамжийн зардал
Кредит: Зохицуулалтын хураамжийн өглөг

Зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Санхүүгийн зохицуулах хороонд төлөхөд:

Дебет: Зохицуулалтын хураамжийн өглөг
Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

ББСБ нь дотоод журам, эрх бүхий удирдлагын шийдвэрээр ажилчдад тогтмол болон цаг үеийн хөнгөлөлт үзүүлж болно.

Хөнгөлөлт олгох үед, олгохоор тооцсон дүнгээр:

Дебет: Хөнгөлөлтийн зардал
Кредит: Цалингийн өглөг

Б. Үндсэн бус үйл ажиллагааны зардал

Үндсэн бус үйл ажиллагааны зардлыг зардлын төрлөөр ангилж бүртгэнэ. Тухайлбал;

Эрх зүйн болон бусад зөрчлийн улмаас торгууль төлбөл:

Дебет: Торгуулийн зардал
Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

Үндсэн хөрөнгө данснаас хасахад алдагдал гарвал:

Дебет: Холбогдох зардлын данс

Кредит: Үндсэн хөрөнгө

В. Орлогын албан татварын зардал

ББСБ нь тайлант үеийн татвар ногдох орлогын хэмжээг Монгол Улсын татварын хуулийн дагуу тооцож, тухайн дүнгээс тайлангийн үед ногдох орлогын албан татварын зардлыг тодорхойлно.

Энэ бүртгэл нь татварын зардлыг холбогдох хугацаатай нь уялдуулна.

Дебет: Орлогын татварын зардал

Кредит: Орлогын албан татварын өглөг

Орлогын татварыг урьдчилж төлөхөд тайлангийн үеийн дундуур хөрөнгө хэмээн бүртгэнэ.

Дебет: Урьдчилж төлсөн зардал

Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

Тайлант үеийн эцсээр байгууллагын орлогын албан татварын тооцоо хийж татварын зардлыг бүртгэхэд:

Дебет: Орлогын татварын зардал

Кредит: Орлогын албан татварын өглөг

Тайлант үеийн эцэст урьдчилж төлсөн татвар, татварын өглөг дансдыг хооронд хааж, тайлант үеийн эцсээр орлогын татварын илүү төлөлт ба өглөгийг тодорхойлно.

Дебет: Орлогын албан татварын өглөг

Кредит: Урьдчилж төлсөн зардал

Жич: ББСБ-ын ердийн үйл ажиллагаанаас илт ялгаатай үйл явдал, ажил гүйлгээнээс үүсдэг байнга давтагдан гарахгүй орлого ба зардлыг ердийн бус орлого, зарлага гэнэ. Тухайлбал байгалийн гамшиг болон гэнэтийн ослоос үүссэн давагдашгүй хүчин зүйлийн гарз хохирол зэрэг болно.

Ердийн бус орлогыг Орлогын тайланд тусгахдаа ердийн үйл ажиллагааны үр дүнгээс тусгаарлан, тайлант үеийн цэвэр ашигт оруулж тооцно.

Г. Ердийн бус зардал

ББСБ-ын ердийн үйл ажиллагаанаас илт ялгаатай үйл явдал, ажил гүйлгээнээс үүсдэг байнга давтагдан гарахгүй зардлыг ердийн бус зардал гэнэ. Тухайлбал байгалийн гамшиг болон гэнэтийн ослоос үүссэн гарз хохирол, бэрхшээлтэй өрийн шинэчлэл гэх мэт.

Онцгой шинжтэй зүйлийн шинж чанар болон дүнг Орлогын тайланд тусгахдаа ердийн үйл ажиллагааны үр дүнгээс тусгаарлан, тайлант үеийн цэвэр ашигт оруулж тооцно.

Е - ББСБ-ЫН САНХҮҮГИЙН ЖИЛИЙН ХААЛТЫН ГҮЙЛГЭЭ

ББСБ санхүүгийн жилийн тайланг энэхүү журмын дагуу үнэн зөв гаргана. Санхүүгийн тайланд тэнцэл, орлого үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан орно.

Хяналт ба бүртгэл

Гүйлгээг үнэн зөвөөр тэнцэлд тусгахын тулд дансдын гүйлгээг нийлж, тохируулж, төлбөр тооцооны үндсэн баримтыг бүрдүүлэн шалгаж баталгаажуулна.

Залруулгын гүйлгээг зохих журмын дагуу зөв хийж байна.

Санхүү, төлбөрийн чадварын байдалд үнэн зөв шинжилгээ хийж, санхүүгийн жилийн байгууллагын ашиг, алдагдлыг үнэн зөвөөр гаргасан эсэхэд хяналт тавина.

Орлого, зарлагын гүйлгээг зориулалтын бус дансанд бүртгэхийг хатуу хориглоно.

Е-1 САНХҮҮГИЙН ЖИЛИЙН ХААЛТЫН ГҮЙЛГЭЭНИЙ БҮРТГЭЛ

Тайлант жилийн эцэст ББСБ, түүний салбарууд орлого зардлын дансдыг тухайн жилийн ашиг, алдагдлын дансанд хааж, тухайн жилийн цэвэр ашиг, алдагдлыг тодорхойлно.

Орлогын дансдыг хаахад:

Дебет: Орлогын бүх дансд
Кредит: Тухайн жилийн ашиг/алдагдал

Зардлын дансдыг хаахад:

Дебет: Тухайн жилийн ашиг/алдагдал
Кредит: Зардлын бүх дансд

Ашиг, алдагдлын дансны хаалтын бичилтүүд нь санхүүгийн тайлангууд /баланс, орлого үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан/-ын хоорондын уялдааг хангаж, хөрөнгө түүний эх үүсвэрийг тохируулахад ашиглана.

Тухайн жилийн ашиг, алдагдлын дансны цэвэр үлдэгдлээр тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал тодорхойлогдох ба тухайн дансны үлдэгдлийг хуримтлагдсан ашиг дансанд хаана.

Тайлант хугацаанд ББСБ ашигтай ажилласан бол цэвэр ашгийн дүнгээр:

Дебет: Тухайн жилийн ашиг
Кредит: Хуримтлагдсан ашиг

ББСБ алдагдалтай ажилласан бол алдагдлын дүнгээр:

Дебет: Хуримтлагдсан ашиг

Кредит: Тухайн жилийн алдагдал.

Ё-1 БУСАД

Ё-1 ТЭНЦЛИЙН ГАДУУРХ ДАНСД

1. Тодорхойлолт

Тэнцлийн гадуурх дансд нь хүлээж болзошгүй үүрэг үнэ бүхий зүйлс, тэнцлээс хасагдсан хөрөнгийн тооцоо зэрэг ББСБ-ын зарим үйл ажиллагааг нарийвчлан тусгах бүртгэл юм.

2. Хамрах зүйлс

- Хүлээж болзошгүй үүрэг
- Эрсдэлийн сангаас хаасан тооцоо
- Зээлийн барьцаа эд хөрөнгө
- Орон байшингийн схем зураг
- Үнэ бүхий зүйлс

3. Хүлээж болзошгүй үүрэг, үнэ бүхий зүйлс

ББСБ-аас өөрийн болон харилцагчийн нэрийн өмнөөс гаргасан батлан даалт, нээсэн зээлийн шугам, аккредитив зэрэг бусдын өмнөөс хүлээх үүрэг.

Өртөг агуулсан, үнэлж болохуйц, ББСБ-ын үйл ажиллагаанд хэрэглэгдэх нарийн бүртгэлтэй маягтууд, цахим карт, хэрэглэгдэж буй тэмдгүүд, төлбөрийн карт зэрэг үнэ бүхий зүйлс.

4. Үнэлгээ

Тэнцлийн гадуур бүртгэлтэй зүйлсийг нэрлэсэн үнэ болон тоо ширхэгээр нь бүртгэнэ. Тэнцлийн гадуурх дансанд зөвхөн орлогодох эсвэл зарлагадах бичилт хийнэ.

5. Санхүүгийн тайланд тусгах

Тэнцлийн гадуур бүртгэлтэй зүйлсийг нэр төрлөөр нь ангилж санхүүгийн тайланд тусгана.

6. Хяналт ба бүртгэл

Үүргийн эрсдэлийг тооцож эрсдэлийн санг зардлаар байгуулна. Үүрэг хүлээж болзошгүй үйл ажиллагааг эрх бүхий удирдлагын зөвшөөрлөөр хийсэн эсэх, батлан даалт гаргагч болон гаргуулагчийн харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг нарийвчлан заасан эсэхэд үндэслэн хүлээж болзошгүй үүргийн дансаар дэлгэрэнгүй бүртгэл хөтөлнө.

Ё-2 ТӨЛБӨРИЙН БАТАЛГАА

Төлбөрийн баталгааны гэрээгээр ББСБ нь үүрэг гүйцэтгэгчийн бичгээр тавьсан шаардлагаар үүрэг гүйцэтгэгчийн өмнөөс мөнгөн төлбөрийг гүйцэтгэх, үүрэг гүйцэтгэгч нь баталгаа гаргагч ББСБ-д төлбөр төлөх үүргийг тус тус хүлээнэ.

Санхүүгийн тайланд тусгах нь

Төлбөрийн баталгааг тэнцлийн гадуурх дансанд нэрлэсэн үнээр нь орлогодоно.

Хяналт

Тэнцлийн гадуурх дансны гүйлгээ үлдэгдэлд тэнцлийн дансны нэгэн адил хяналт тавьж ажиллана. ББСБ-ын дотоод хяналтын албанаас гүйлгээ, үлдэгдэл нэг бүрийг шалгаж холбогдох арга хэмжээг тухай бүрт авч гүйлгээг буруу хийсэн тохиолдолд холбогдох заавар, журмын дагуу хариуцлага тооцож байна.

Ё-2.1 ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ БИЧИЛТ

ББСБ нь өөрийн нэрийн өмнөөс бусдад төлбөрийн баталгаа гаргахад тэнцлийн гадуурх дансны хүлээж болзошгүй үүргийн дансанд орлого болгон авна.

Төлбөрийн баталгааны хугацаа болон харилцагчийн нэрийн өмнөөс гаргасан баталгааны хугацаа дуусахад, харилцагч зээлээ төлж чадаагүйгээс ББСБ зээлийг төлж барагдуулах болсон нөхцөлд зээлийн төлбөрийг хийхийн өмнө зээлийн хувийн хэрэг, төлбөр тооцоо хийсэн баримт болон холбогдох баримт материалыг тухайн зээлийг олгосон этгээдээс хувилуулан авсны эцэст тэнцлийн гадуурх данснаас зарлага гарган дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Дебет: Зээлийн холбогдох данс /харилцагчийн нэрээр/

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс гэсэн бичилт хийж байгууллагын тайлан тэнцэлд зээл болгон бүртгэн авч зээлийн үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу бүртгэнэ.

Ё-3 ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

3.1. Байгууллагын удирдлага дараах нөхцлийг хангаж ажиллана. Үүнд:

3.1.1. Байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг өдөр, сар, улирал, жилээр үнэн зөв гаргах;

3.1.2. Байгууллагын нягтлан бодох бүртгэлийг мэргэжлийн өндөр түвшинд нэгдсэн бодлогын хүрээнд явуулах;

3.1.3. Байгууллагын нягтлан бодох бүртгэл болон бусад үйл ажиллагааг энэ журам болон Монгол улсын хууль тогтоомж, Хорооноос батлагдах бусад журамд заасан шаардлагын хэмжээнд хангаж ажиллах;

3.1.4. Дотоод хяналтын алба ажиллуулж, өөрийн үйл ажиллагаанд өдөр тутмын хяналт тавих.

3.2. Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд:

3.2.1. Зориулалтын бус дансаар гүйлгээ хийх, түүний дотроос зээл болон авлагыг зориулалтын бус дансаар бүртгэх;

3.2.2. Санхүүгийн жилд үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэлийг бодохгүй байх;

3.2.3. Данс бүртгэлийг будлиантуулах;

3.2.4. Зээл, хадгаламжийн хүүгийн тооцоог удаа дараа буруу хийх;

3.2.5. Төлбөр тооцооны баримт материалыг дарагдуулах;

3.2.6. Ашиг, алдагдлыг буруу тодорхойлон тайланд зохиомлоор ашигтай гарган ашиг хуваарилах;

3.2.7. Ашгийг санаатайгаар дарагдуулан татвараас зугтаах;

3.2.8. Санхүүгийн тайлан гаргах хугацаа хожимдуулсан зэрэг зөрчлүүд илэрсэн нь тогтоогдвол Монгол улсын хууль тогтоомж, Хорооноос гаргасан холбогдох журмын дагуу зохих хариуцлагыг хүлээлгэнэ.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

---ooOoo---